

МЭРСЭЭГИЙН АМЬДРАЛЫН СҮҮЛИЙН ЖИЛҮҮД

Д.Наранжаргал

Ч.Дашдаваа

Товч утга: Го Дао Фу буюу Мэрсээг 1931 оны 12 дугаар сард Манжуурт сууж байсан Зөвлөлт Холбоот Улсын Элчингийн газар очоод сураггүй болсон гэж үздэг. Гэвч түүнийг мөрдөн байцаасан тухай баримт бичгүүд Оросын Холбооны Улсын Холбооны аюулгүй байдлын албаны (Федеральная служба безопасности Российской Федерации) төв архивт № Р-34587 дугаартай хавтаст хэрэгт хадгалагдаж байна. Энэ хавтаст хэрэг дэх Мэрсээг 1932 оны 5 дугаар сарын 24-нд болон 1933 оны 11 дүгээр сарын 20-нд байцаасан тэмдэглэл, 1932 оны 9 дүгээр сарын 16-нд “Нөхөр даргад” хэмээн хаяглаж Мэрсээгийн бичсэн зүйл, Алс дорнодын хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдлагын Бүрэн эрхт төлөөлөгчийн газарт Мэрсээгээс 1933 оны 1 дүгээр сарын 18-нд бичсэн мэдэгдэл, Мэрсээд оноосон ялын дүгнэлт, Мэрсээгийн хэргийг хүчингүйд тооцсон тодорхойлолт зэрэг баримт бичгүүдийг орос хэлнээс орчуулж, хавсралт болгон нийтэлж байна.

Түлхүүр үг: Мэрсээ, Оросын Холбооны Улсын Холбооны аюулгүй байдлын албаны төв архив, хавтаст хэрэг

Го Дао Фу буюу Мэрсээгийн амьдрал үйл ажиллагааны тухай Дундад улс, Монголын эрдэмтдийн хийсэн судалгааны ажлын үр дүнд эрдэм шинжилгээний олон бүтээл нийтлэгджээ. Мэрсээ 1931 оны 12 дугаар сард Манжуурт сууж байсан Зөвлөлт Холбоот Улсын Элчингийн газар очоод сураггүй болсон гэж ихэнхи судлаачид бичиж байна. Үүнээс хойшхи үеийн Мэрсээгийн амьдрал, үйл ажиллагааг судалсан ямар нэг бүтээл гараагүй бололтой.

Манжуур дахь Зөвлөлтийн консулын газар ирсэн Мэрсээг Зөвлөлтийн зохих албаны ажилтнууд баривчилж, нууцаар хил давуулан ЗХУ-д аваачжээ. 1934 онд ЗХУ-ын Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын газрын зөвлөлөөс гаргасан тогтоолоор Японы тагнуулын байгууллагын даалгавраар тагнуул хийж байсан, зэвсэгт бослого гаргахаар бэлтгэж байсан, зэвсэгт мөргөлдөөнд өдөөн турхирахыг оролдсон гэсэн ялыг Мэрсээд тулгаж, буудан алах ял оноожээ.

Мэрсээг мөрдөн байцаасан тухай баримт бичгүүд Оросын Холбооны Улсын Холбооны аюулгүй байдлын албаны (Федеральная служба безопасности Российской Федерации) төв архивт № Р-34587 дугаартай хавтаст хэрэгт хадгалагдаж байна. Энэ хавтаст хэргийн хуудас 2-8, 31-33, 142-144, 157- 158-д байгаа баримт бичгүүдтэй танилцах боломж бидэнд олдсон юм. Мэрсээг 1932 оны 5 дугаар сарын 24-нд болон 1933 оны 11 дүгээр сарын 20-нд байцаасан тэмдэглэл, 1932 оны 9 дүгээр сарын 16-нд “Нөхөр даргад” хэмээн хаяглаж Мэрсээгийн бичсэн зүйл, Алс дорнодын хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдлагын Бүрэн эрхт төлөөлөгчийн газарт Мэрсээгээс 1933 оны 1 дүгээр сарын 18-нд бичсэн мэдэгдэл, Мэрсээд оноосон ялын дүгнэлт, Мэрсээгийн хэргийг хүчингүйд тооцсон тодорхойлолт зэрэг баримт бичгүүдийг орос хэлнээс орчуулж хавсралт болгон нийтэлж байна.

Мэрсээг Манжуур дахь ЗХУ-ын консулын газарт 1931 оны 12 дугаар сарын 11-нд очиход нь ЗХУ-ын Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын ажилтнууд баривчилжээ. Мэрсээг нууцаар хил давуулж Хабаровск хот дахь Алс Дорнодын хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн газарт мөрдөн байцаах ажил явуулжээ. Мэрсээгээс 1932 оны 5 дугаар сарын 24-ны өдөр авсан байцаалтын тэмдэглэл нь Мэрсээд нээсэн Р-34587 дугаартай эрүүгийн хавтаст хэргийн 2-8-р хуудсанд байна. Байцаалтын тэмдэглэлийг орос хэл дээр гараар бичжээ. Тэхээр Мэрсээг баривчилснаас хойшхи 5 сар гаруй хугацаанд Мэрсээгээс мэдүүлэг авсан эсэхийг тодорхойлоход бэрх ажээ. Мэрсээ 1932 оны 5 дугаар сарын 24-ны өдөр өгсөн дээрх мэдүүлэгтээ төрсөн он, газар, яс үндэс, боловсрол, гэр бүл, хөрөнгө чинээний байдал зэргээ тодорхойлохын хамт өөрийнхөө амьдралын замналыг бага наснаасаа эхлэн 1928 онд Баргад хуралдсан ӨМАХН-ын их хурал хүртэлх үеийг хамран дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Мэрсээ энэхүү мэдүүлгийнхээ эцэст “дээр дурдсан зүйлүүдийг миний хэлснээр зөв бичсэн байна, ийм учраас би гарын үсэг зурав. Орос хэл сайн мэднэ. Иймээс орчуулагч хэрэглээгүй болно. Мерсе” гэжээ (Баримт №1).

Баргад тогтоосон харчингуудын ноёрхлыг эсэргүүцсэн тэмцэлд оролцсон, монгол сургууль байгуулсан, Ринчиновтой холбоо тогтоосон, Улаанбаатар, Москвад хийсэн ажил, Ардын хувьсгалт намын Баргын хороог болон ӨМАХН-ыг байгуулсан, Улаанбаатар хотод ӨМАХН-ын Төв хорооны гүйцэтгэсэн ажил зэрэг 1928 онд Баргад намын их хурал хуралдах хүртэлх үеийн Мэрсээгийн улс төрийн үйл ажиллагааг тодруулахад түүний энэ мэдүүлэг тус болох нь эргэлзээгүй.

“Нөхөр даргад” хэмээн гарчигласан бичгийг Мэрсээ 1932 оны 9 дүгээр сарын 19-нд бичжээ. Бичгийн машинаар орос хэл дээр бичсэн энэ бичгийн зүүн дээд өнцөгт “перевод с китайского” буюу “хятад хэлнээс орчуулсан” гэж гараар цохжээ. Үүнээс үзэхэд уг бичгийг Мэрсээ анх хятад хэлээр бичсэн бололтой. Мэрсээ бичгийнхээ эхэнд: “Шоронгийн 8 дугаар өрөөнд

сууж буй миний бие тантай хийсэн ярилцлагын дараа, надад өгсөн сайхан ном, зөвлөлтийн сониныг уншсаны дараа оюун санаанд маань эргэлт гарсныг мэдэрсэн, большевикууд Лениний онолыг хатуугаар, үнэн зөвөөр хэрэгжүүлж, социализмыг амжилттай байгуулж байгааг мэдэв. Японы империализмд үйлчлэхэд хүргэсэн өөрийн алдаатай үзэл бодол, буруу үйл ажиллагаагаа би одоо нэн тодорхой ухамсарлав. Ийм учраас энэхүү мэдэгдэлдээ өөрийн алдаагаа үнэн сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэхийн хамт Японы гар хөл болсоны шалтгааныг тодорхойлохыг эрмэлзсэн болно” гэж дурджээ.

Улаанбаатарт байх үедээ Ц.Дамбадорж, Ж.Цэвээн нарын нөлөөнд автагдаж байсан тухай Мэрсээгийн бичсэн зүйл нилээд бодитой мэт. Мэрсээ бичихдээ: Өргөөд ажиллаж байхдаа нөхөр Дамбадоржийн оюун санааны нөлөөнд автагдаж байгаагаа мэдэрч байсан юм. Дамбадорж тэр үед ЗХУ ба Коминтерний бодлогыг үнэлэх талаар барууны хэлбэрэл гаргасан бөгөөд тэрээр дараах үзлийг баримталж байжээ. Үүнд: 1). Монголын ард түмнүүд нэгдэх явдалд ЗХУ, Коминтерн саад учруулж байна, 2). Бие даасан байх, өөрийн дипломат бодлогоо явуулах боломжийг Гадаад Монголд олгохгүй байна, 3). Бие дааж эдийн засгаа хөгжүүлэх боломжийг (аливаа улс орнуудтай чөлөөтэй харилцах явдлыг) олгохгүй байна.

Нөгөө талаар миний ихэд хүндэтгэдэг, монголизмын эцэг, эрдэмтэн Жамсарановын нөлөө бас их байв. Түүний үзэл гэвэл: 1). Монголчууд нэгдэн нийлсэн цагтаа л төр улсаа байгуулж чадна, 2). Монгол орон ганцхан улсыг түшиглэх ёсгүй, 3). Монгол улс өөрийн далайн зогсоолтой байх зэрэг болно.

Ийм үзэл бодлын нөлөөгөөр ЗХУ, Коминтерний бодлогод итгэх явдалд эргэлзээ төрж, урьдын үндсэрхэх үзлийн хүмүүжил маань дахин сэргэсэн юм” гэсэн байна. (Баримт № 2).

ЗХУ-ын гадаад бодлого, пролетарийн хувьсгалын зарчим, үндэсний асуудлаарх Ленин, Сталины үзэл бодол, БХКБН-ын эгнээн дэх хагарлыг ойлгохгүй байсныгаа Мэрсээ энэхүү бичигтээ онцлон тэмдэглээд баруун ба зүүн хэмээсэн үзэл бодлын ялгаа байна, Лениний бодлого бол баруунтныг төлөөлж байна гэж ойлгож байсан, ийм учраас ЗХУ, Коминтернд талархалтай хандах тухайд бүр ч их эргэлзэх болсон хэмээн Мэрсээг бичжээ. Түүнчлэн Гадаад Монголын Ардын Нам баруун, зүүн гэсэн хоёр хэсэгт хуваагдсан үед тэрхүү эвдрэл маргаанд оролцохгүй байхыг хичээсэн, Коминтерний зөвшөөрлийг хүлээлгүйгээр Баргад бослого гаргах тэмцлийн замд өөрийн дур зоргоор орсон, ЗХУ ба Гадаад Монголоос тусламж авч чадахгүй гэдгээ сайн мэдэж байсан, япончуудын тусламж дэмжлэгийг авахаас өөр аргагүй байсан учир Шао Линаар дамжуулж япончуудад бичиг хүргүүлсэн, гэвч Баргын бослого дарагдсан, Улаанбаатарт буцаж очвол Гадаад Монголын нам, Коминтернээс шийтгэл хүлээх байсан учир Жан Сю Елины талд орсон гэж Мэрсээ бичжээ. Мэрсээгийн энэхүү тайлбарт үнэний хувь багагүй байгааг судлаачид анхаарах ёстой гэж үзэж байна.

Үүнээс гадна Японы гар хөл болсноо хүлээ хэмээх байцаагчийн тулгалтанд автсан шинжтэй зүйлийг ч Мэрсээ бас бичжээ. Японы нөлөө Өвөр Монголд хүчтэй болсон үед хоёр дарлагчтай байснаас ганц дарлагчтай байсан нь дээр гэж бодох болсон, үндэсний хувьсгалт тэмцлийг цаашид өрнүүлэхэд Гадаад Монгол болон ЗХУ-аас тусламж үзүүлнэ гэдэгт найдах аргагүй болсон учир Японы тусламжийг ашиглах ганц гарц үлдсэн, Монголын эрх ашгийн төлөө ажиллаж байна гэж итгэж байсан боловч хэрэг дээрээ Японы империализмд үйлчлэхэд хүрсэн гэсэн тайлбарыг Мэрсээ хийсэн байна. Баргын 1928 оны үйл явдлын дараа намайг өөртөө татах гэсэн оролдлогыг япончууд хийх болсон гэдгийг Мэрсээ онцлон тэмдэглэжээ. Үзэл бодлоо өөрчилсөн, Японы гар хөл болсон зэргээр уучилж болшгүй том гэмт хэрэг үйлдсэнээ ухамсарлаж байна гэж Мэрсээ бичжээ.

Өвөр Монголд зориулсан ном бүтээлийг туурвих шаардлагатай тухай саналыг Мэрсээ энэ бичигтээ дэвшүүлжээ. Ингэхдээ дараах хоёр зүйлийг онцлон тэмдэглэсэн аж. Үүнд: Нэгдүгээрт, Монголын дотоодод “Нармай Монгол”, “Япон, Монголын найрсаг харилцаа” зэрэг ухуулга хүчтэй болсон, “язгууртны үзэл”, “ламын ёс”, “Их гүрний түүхэн шовинизм” зэрэг нь олон түмэнд хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд тэдгээр нь хувьсгалт үзэл санааг хүлээн авах хөрс суурийг үгүй болгож байна. Хоёрдугаарт, ЗХУ-д социализмыг яаж байгуулж ирсэнийг, зөвлөлтийн үндэстэн ястнууд аз жаргалтай сайхан амьдралаа хэрхэн бүтээн босгосныг Өвөр Монголын ард түмэн мэдэхгүй байгаа төдийгүй, Гадаад Монголыг чөлөөлсөн явдал бол үндэстний мөхлийн эх хэмээн үзэж байна гэжээ.

Мэрсээ дээрх бодит байдалд үндэслэн “Гадаад Монгол ба ЗХУ дахь бодит байдлыг тайлбарлах, Өвөр Монголд хувьсгалт үзэл санааг дэлгэрүүлэхэд түлхэц үзүүлэх, Японы империализмын хортой ухуулгад няцаалт өгөх, Монгол дахь түүний хүч чадлыг сулруулах, Өвөр Монголын хоцрогдсон ахуй нөхцлийг эвдэхэд чиглэгдсэн байх ёстой. Энэ үндсэн дээр Японы империализмыг эсэргүүцсэн Зөвлөлтийн эрх ашгийг хамгаалах хэрэгт Өвөр Монголыг ойртуулах ёстой юм” гэсэн дүгнэлт хийжээ.

Энэ үйлсэд ашиг тус үзүүлж чадна гэж үзэж байгаагаа Мэрсээ илэрхийлээд “Миний бие гэмт хэрэг үйлдсэнээ ухамсарлахын хамт өөрийн төөрөгдлийн жинхэнэ шалтгааныг чин сэтгэлээсээ илэрхийлсэн. Ийм учраас миний шийтгэлийг хөнгөвчлөх талаар тусламж үзүүлэхийг нөхөр дарга танд хүсэлт болгож байна” гээд “Хувьсгалын ашиг тусын төлөө, ард түмнийхээ төлөө тустай зүйл хийнэ гэдгийг би ажил хэргээрээ нотолж чадна, ингэж би гэмээ арилгана” гэжээ (Баримт №2).

Алс Дорнодын Хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн газарт 1933 оны 1 дүгээр сарын 18-нд Мэрсээгийн бичсэн “мэдэгдэл” хэмээх бичигт: урьд өмнө үндэсний чөлөөлөх тэмцэлд хүчээ өгч байсны нэгэн адил одоо ч гэсэн ганц өөрийн биеийг бодож байгаа

бус харин нүглээ наминчилснаараа сэтгэл санааны хувьд тайвширч, ажил хөдөлмөрөөр өөрийн алдааг засч залруулахыг хүсч байна” гэдгийгээ дахин илэрхийлжээ (Баримт №3).

Япончуудтай тогтоосон хэлхээ холбооны тухай бүх зүйлийг ярихгүй байна, Японы ажил хэрэгч бүлгийнхнээс авсан даалгавраа нэгийг нь ч биелүүлээгүй мэт мэдүүлэг өгч байна, Японы төлөөлөгчдөөс хэдэн удаа ямар хэмжээний зүйл авсаныгаа яагаад мэдүүлэхгүй байна вэ хэмээн байцаалтын үеэр Мэрсээгээс удаа дараа асууж анхааруулж байсныг энэ мэдэгдэлд онцлон дурджээ.

1928 онд Баргын бослого гарах хүртэлх үед зөвлөлтийн талыг баримталж байсан, Японы төлөөлөгчидтэй ямар ч холбоо барьж байгаагүй. Баргын нөхцөл байдал нь ЗХУ болон Гадаад Монголын зүгээс тусламж үзүүлэхээс татгалзсантай холбогдон бослого гаргагчдад тусламж үзүүлэхийг амалсан Японы төлөөлөгчдийн саналыг хүлээж авахаас өөр аргагүй байдалд хүрснийг Мэрсээ онцлон тэмдэглээд “Японы ашиг сонирхолд миний ойртсон явдлыг эхлээд болгоомжтой судалж эхэлсэн, харин жирийн тагнуул болгож намайг ашиглах гэж эрмэлзсэнгүй, Монгол дахь Японы байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн соёлын болон улс төрийн томоохон арга хэмжээнүүдийг зохиоход миний нэр төр, хүч, хэлхээ холбоог ашиглахыг гол болгожээ” гэж тайлбарлан өгүүлжээ.

Японыг баримтлагч боловсон хүчнийг бэлтгэх, Монголын ноёдтой залуучуудын тогтоосон найрамдлыг бэхжүүлэх, “Монгол соёлын төвүүд”, “Сейм ба хошууны хороод” гэх мэтийн монгол ноёдын ашиг сонирхлыг бэхжүүлсэн холбоодыг зохион байгуулах, залуучуудыг Японд талархалтай болгох, “Нармай Монгол” гэх мэтийг дээдэлдэг үндсэрхэх үзлийг өдөөх зэрэгт миний ажил чиглэгдсэн гэж Мэрсээ өгүүлжээ. Япончуудаас тагнуулын шинжтэй жижиг даалгавар авч биелүүлж байгаагүй, Японыг баримталсан арга хэмжээг зохиоходоо япончуудаас мөнгө төгрөг нэхэж байгаагүй гэдгийг Мэрсээ тэмдэглэжээ.

Намайг мөрдөн байцаасны эцэст Японы тагнуул, улс төрийн хутган үймүүлэгч хэмээх ялыг надад тулгав гэж Мэрсээ тэмдэглээд хэрэв 6-7 сарын өмнө ийм ял оноосон аваас хүчирхийллийн илрэл хэмээн үзэх байв, харин одоо бол гэмт явдлаа ухамсарласан гэжээ. Нөхөдтэйгөө хийсэн ярилцлага, сонин уншлага, улс төрийн ном зохиол, ялангуяа Сталины сүүлчийн хэлсэн үгтэй танилцсан зэрэг нь надад их тус болсон гэж Мэрсээ бичжээ.

Энэ бүхнийг тэмдэглэсний эцэст “одоо бол төөрөлдсөн гэмт явдлаа хүлээсэн, аргаа барахдаа бүхнийг илчлэн ярьж нүглээ наминчилсан хүн Таны өмнө зогсож байна. Би өөрийгөө дахин төрсөн мэтээр бодож байна, дарлагдсан олон түмнийг чөлөөлөхийн тулд пролетарч санаа сэтгэлээр ажиллана гэдгээ илэрхийлж байна. Миний хувь заяа шийдэгдэж байгаа асуудлын өмнө, өнөө үеийн өмнө би зогсож байна. Таны байгаа энэ газарт,

эсвэл Монголд, хаа ч байсан, өөр нөхцөлд ажил хэрэгт тань тус болно гэдэг өөрийн хүсэл, хувийн баталгаа гаргахаас өөр юм надад алга. Би хувьсгалт ёсоор үр ашигтай байхыг хүсч байна, тийм ч байж чадна, үүнийг ажил хэргээр нотлон харуулах боломжийг надад олгохыг танаас хүсч байна” гэжээ. Марксизм ленинизмийн бүтээл, коммунист намын баримт бичгүүдтэй танилцах, орос хятад толь ашиглах зөвшөөрөл олгох, Өвөр Монгол, Баргын хүн амыг хувьсгалжуулах эрх ашгийн үүднээс улс төрийн толь зэргийг бичих ажилд орох, сурталчилгааны ном бүтээл туурвих боломж олгохыг хүсчээ.

Мэрсээг 1933 оны 11 дүгээр сарын 20-нд байцаасан тэмдэглэлийг бид “Баримт №4”-т нийтэлж байна. Монгол улсад гарсан Лхүмбийн хэрэг гэгчтэй холбогдуулан нэмэлт байцаалтыг Мэрсээгээс авчээ. “Өмнөх мэдүүлэгтээ дурдсан, нэмэлт болгож дараах зүйлийг өгүүлье”, “би дараагийнхаа мэдүүлэгт ярьж өгнө” хэмээн Мэрсээгийн хэлсэн үг нь энэхүү байцаалтаас өмнө олон удаа мэдүүлэг өгч байсныг гэрчлэх ажээ. Инокучи хэмээх япон хүн Монголд нэвтрэхийг оролдсон тухай, Манжуур дахь японы консулыг БНМАУ-д очуулах талаар Фуминтайгийн хийсэн ажлын тухай, Эрхэмбаяр, Нунхейжавын холбоочноор ажиллаж байгаад БНМАУ-аас зугтаж гарсан тухай зэрэг Мэрсээгийн мэдүүлгүүд нь тухайн үеийн зарим түүхэн үйл явдлыг тодруулахад тус дөхөм үзүүлж магадгүй.

Мэрсээд оноосон ялын дүгнэлтийг “Баримт №5” оруулав. Мэрсээд оноосон ялын агуулга, үндэслэлийг олж мэдэхэд энэ баримт бичиг чухал ач холбогдолтой юм. Японы тагнуулын байгууллагын даалгавраар тагнуулын ажил хийсэн, Өвөр Монголыг Японд эзлүүлэх зорилгод чиглүүлэн Өвөр Монгол дахь Японыг баримталсан, боловсон хүчнүүдийг нэгтгэх бодлого явуулж томоохон зэвсэгт бослого гаргахаар бэлтгэж байсан, ЗХУ-ыг Японы эсрэг зэвсэгт мөргөлдөөнд өдөөн хатгах оролдлого хийсэн хэмээх ял тулгаж ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58 дугаар заалтын 4,6 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэргийг үйлдсэн гэжээ.

Үүнээс үзэхэд Мэрсээд хилс ял тулгаж хэлмэгдүүлсэн нь тодорхой ажээ. Өөр улсын харьяат хүнийг Зөвлөлтийн хуулиар шийтгэх нь хууль бус үйлдэл болох нь ч тодорхой.

ЗХУ-ын Цэргийн Ерөнхий прокурорын орлогч, хууль зүйн хошууч генерал В.С.Парфеновоос 1989 оны 5 дугаар сарын 19-нд баталсан Мэрсээд оноосон шийтгэлийг хүчингүй болгосон тухай тодорхойлолт буюу “Баримт № 6”-аас Мэрсээгийн амьдрал, хувь заяатай холбоотой зарим чухал мэдээг үзэж болно. Тухайлбал,

Нэгдүгээрт, Мэрсээг баривчилсан, ял тулгасан, хэрэг шийтгэсэн баримт бичгүүд хавтаст хэрэгт нь байхгүй ажээ.

Хоёрдугаарт, Мэрсээг Манжуур өртөөн дэх ЗХУ-ын консулын газарт 1931 оны 12 дугаар сарын 11-нд Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын

ажилтнууд нууцаар баривчилсан байна.

Гуравдугаарт, Мэрсээг мөрдөн байцаах ажлыг эхлээд Алс Дорнодын хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Бүрэн эрхт төлөөлгчийн газарт, дараа нь Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Гадаад хэлтэст явуулсан байна.

Дөрөвдүгээрт, Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Зөвлөлийн 1934 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлийн 4,6 дахь заалтуудын дагуу Мэрсээд буудан алах ял оноож, улмаар түүнийг 10 жилийн хугацаагаар шоронд хорих шийтгэлээр өөрчилжээ.

Тавдугаарт, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдээс 1989 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр гаргасан “30-40-өөд он, 50-иад оны эхэн үед хэлмэгдүүлэлтэд өртөгчдийн тухайд шудрага ёсыг тогтоох талаар авах нэмэлт арга хэмжээний тухай” зарлигийн 1 дүгээр заалтад Мэрсээг хамааруулах явдлыг энэхүү тогтоолоор шийдвэрлэжээ. Ингэж Мэрсээг гэм буруугүй хэмээн цагаатгажээ.

Мэрсээгийн амьдралын сүүлийн жилүүдийг төдийгүй бүхийл амьдрал, үйл ажиллагааг нь судлан тодруулахад ихээхэн тус үзүүлэх эдгээр 6 баримт бичгийг орос хэлнээс монгол хэлэнд орчуулж хавсралтаар нийтэлж байна. Мэрсээд оноосон буудан алах шийтгэлийг шоронд 10 жил хорих ялаар өөрчилсөн тухай, Мэрсээ энэ ялыг хаана, хэрхэн эдэлсэн, хэзээ, хаана, яагаад нас барсан зэргийг тодруулах баримтыг хайж олох зорилт тулгарч байна.

Abstract: It is accepted that Go Dao Fu or Mersee has been disappeared from the Soviet Embassy in Manchuria in December 1931. However, it was fortunate for us to discover a file of Mersee with documents on his interrogation at the central archives of the Federal Security Service of the Russian Federation. In this paper it is revealed the file related to Mersee's interrogation, verdict for his sentence, the statement of recalling the verdict and other materials produced in 1932-33 which were attached with Mongolian translation.

Хавсралт. Баримт №1-6.

Баримт № 1. БАЙЦААЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

1932 оны 5 дугаар сарын 24.

Мерсе буюу Го Дао Фугийн талаарх

Эрүүгийн хэрэг: № Р-34587

1932 оны 5 дугаар сарын 24-ны өдөр Алс Дорнодын хязгаарын (1) Улс төрийн удирдах газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын 1 дүгээр салбарын

даргын туслах миний бие дор нэр дурдсан яллагдагчаас хуулийн заалтыг баримтлан байцаалт авав.

Овог нэр: Мэрсээ (Го Дао фу)

Нас: 1894 онд төрсөн.

Яс үндэс: Монгол-барга, БНХУ-ын харьяат

Төрсөн газар: Барга, Жаромт тосгон

Ангийн харьяалал: түшмэлийн хүү.

Хөрөнгө чинээний байдал : Үхэр 300-400 толгой, Адуу 100-200 толгой

Хонь 500 толгой

Хайларт байшинтай, тосгонд байшинтай

Банкинд бэлнээр 10 000 хятад доллар бий

Хайлаарт ойролцоогоор 20 000 хятад долларын

үнэтэй спиртийн завод бий, 30 ширхэг тэрэгтэй

Хийж байсан ажил: Мүгдэнд сүүлийн жилүүдэд Монголын семинарын захирал

Боловсрол: Хятадын дээд боловсролтой, орос хэл мэднэ.

Гэр бүлийн байдал: Эхнэртэй, 5-13 насны 3 охинтой

Намын гишүүнчлэлийн байдал: Дотоод Монголын Ардын Хувьсгалт намын гишүүн

Шүүгдэж мөрдөгдөж байсан эсэх: үгүй.

Би бүүр бага байхаасаа өвөг эцэгтэйгээ амьдардаг байсан. Өвөг эцэг маань хоёр ч хошууг захирдаг түшмэл хүн байсан юм. Би 7 настайгаасаа 13 нас хүртлээ манж, хятад хэл бичгийг өвөөгөөрөө заалгасан. Үүний дараа би сургуульд орж хоёр жил суралцсан. Хайлаарын сургуулийн дараа Цицикарын гимназид 4 жил суралцаж төгссөн. Жилийн дараа буюу 21 нас хүрмэгцээ (1915 он) Гадаад харилцааны яамны дэргэдэх орос хэлний Бээжингийн дээд сургуульд элссэн. Энэ дээд сургуульд би 2 жил суралцсан. Сургуулиа төгсөхийн тулд дахиад 3 жил суралцах хэрэгтэй байв. Энэ үед (1917 он) Баргад эмх замбараагүй байдал гарсан учир би цаашид үргэлжлүүлэн суралцаж чадсангүй. Харчингууд миний эцгийг баривчилжээ. Тэр үед Жаромт станцын хавьцаа дүрвэгч мэт байсан эцэг дээрээ очихоор Бээжингээс Барга руу явсан юм. Би эцэгтээ хань болж хэд хоног цуг байсныхаа дараа өвөөгийнхөө хамт Цицикарт очиж тэнд сар гаруй болов. Би Цицикарт гэр бүлийн ажлаас өөр юуч хийсэнгүй. Харчингууд Хайлаарыг эзэлсэний дараа Баргын эрх баригчид бүгдээрээ Цицикарт зугатан очжээ. Энэ үед би Цицикарт байсан бөгөөд Баргын эрх баригчидтай улс төрийн ямарч хэлхээ холбоогүй байв. Харчингууд Баргыг эзэлж аваад түйвээн сүйтгэх болсон учир олон түмний дургүйцлийг зүй

ёсоор хүргэжээ. Цицикарт 1917 оны намар Баргын хуучин эрх баригчдын талынхан хүрэлцэн ирж Харчингийн засаглалыг эцэс болгох арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай болсон тухай асуудлыг дэвшүүлэн тавьжээ. Би үүнийг мэдэж байсан бөгөөд Жаромт станцад байгаа эцэг дээрээ очихоор Барга руу явсан юм. Энэ үед Жаромт станцын хавьцаа миний нөхөр Фуминтай амьдарч байсан учир түүнтэй уулзаад Гадаад Монголд очихоор бид шийдвэрлэв. Манлай вантай уулзаж, Баргын отрядуудыг удирдан Харчингуудыг бутцохиж Баргын эрх мэдлийг гартаа авах явдлыг удирдан зохион байгуулахыг түүнээс хүсэхээр шийдвэрлэсэн билээ. Энэ үед Манлай ван Өргөөгөөс гарч өөрийн хошуундаа (Манлай вангийн хошуу) амьдарч байжээ. Тэрээр бидэнд тусалж, харчингуудын засаглалыг эцэс болгон, удирдлагыг өөртөө авахыг зөвшөөрсөн билээ. Баргын хуучин удирдлага эрх баригч хэвээр үлдэхийг бид хүсээгүй учраас Манлай ванд хандсан билээ. Чухам энэ үе бол миний улс төрийн үйл ажиллагааны эхлэл болсон юм.

Биднийг Манлай вантай ярилцаж байх үед Баргын хуучин удирдлага харчингуудын ноёрхлыг түлхэн унагаж амжсан учир Манлай ван бидний тохиролцоо хэрэгжээгүй билээ. Үүний дараа би Баргын яаманд бичээчээр ажиллах болов. Бичээчээр ажиллахын хамт нийгмийн зүтгэлтэн хүний хувьд Хайлаарт 1918 онд монголын бага сургууль байгуулж захирлаар нь ажиллах болсон юм. 1918 оны эцэст Дээд-Үдэд болсон Буриад-Монголын бага хуралд зочноор оролцов. Энэ бага хурлыг цагааныхан зохион байгуулсан ажээ. Шашны дэг журам, үндэсний хөдөлгөөнийг бэхжүүлэх асуудлыг ярилцсан юм. Энэ бага хурал дээр Буриад-Монголын улс төрийн зүтгэлтнүүдтэй холбоо тогтоох боломжтой болов. Хайлаарт 1920 онд Баргын хоршоог зохион байгуулав. Мэхэртэд монголын бага сургууль байгуулав. Дээд-Үдэд 1918 онд танилцсан нөхөр Ринчиновын (Буриад-монгол) Эрхүүгээс бичсэн захидлыг хүлээн авав. Монголын ард түмнийг чөлөөлөх үйлс цагаантнуудтай бус чухамхүү улаантнуудтай хамтарсан хувьсгалт замаар хэрэгжинэ гэж Ринчино захиандаа бичжээ. Нөхөр Ринчиновын саналыг бүрэн дэмжиж байна хэмээн дээрх захидлыг надад авчирч өгсөн хүнд хэлж билээ. Нөхөр Ринчиновын Өргөөгөөс бичсэн хоёрдахь захидлыг би 1922 онд хүлээн авсан юм. Гадаад Монголд ардын засаг тогтсон, ийм учраас Өргөөд ирээч гэж түүнд бичсэн байв. Хил хаалттай учир Баргаас Гадаад Монголд нэвтрэн орох явдал хүнд хэцүү болсон байв. Ийм учраас би Бээжин явж Монгол-Төвдийн институтэд байцаагчаар орж хоёр сар гаруй ажиллахдаа бүх сурагчидтай танил болж, Монгол Төвдийн институтэд сурагчид элсүүлэх ажлаар Гадаад Монголд томилолтоор явах боломж олж авсан юм. Хил нэвтрэх зөвшөөрөлтэй болсон учир 1923 оны зун Хаалган хотыг дамжин Гадаад Монголд очив. Намайг Өргөөд очиход Ринчинов тэнд байсангүй Москва хот явсан байв. Цэвээн Жамсарано (эрдэмтэн) намайг Өргөөд ирсэн тухай цахилгаан утсыг Ринчинод явуулжээ. Москвад намайг явуулах ажлыг

зохион байгуулахыг хүссэн хариуг Ринчинов ирүүлсэн байв. Энэ ажлыг зохион байгуулж би ч Москва явав. Би Москвад Монголын төлөөлөгчийн газарт Ринчиновын хамт амьдрах болов. Хятадын байдлын тухай миний бичсэн олон илтгэлийг нөхөр Ринчинов Коминтернд шилжүүлэн өгсөн юм. Үндсэндээ Өвөр Монгол, Барга дахь хувьсгалт ажлын тухай ярилцах гэж л нөхөр Ринчинов намайг дуудуулсан ажээ. Москвад сар орчим байсны дараа нөхөр Ринчиновын хамт Өргөө орохоор мордов. Москвагаас гарсан галт тэргэнд Хятадад Бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон нөхөр Карахан явж байсан бөгөөд нөхөр Ринчинов намайг түүнтэй танилцуулав. Өргөөд ирсэний дараа тэнд гурван долоо хоногийг өнгөрөөгөөд Хаалганаар дамжин Бээжинд буцаж очсон болно. Гадаад Монгол болон Өвөр Монгол, Баргын хооронд найрсаг харилцааг хөгжүүлнэ, залуучуудын дунд хувьсгалт ажил зохионо гэж Өргөөгөөс мордохын өмнө нөхөр Ринчиновтой тохиролцсон болно. Бээжинд ирээд Монгол, Төвдийн институтэд байцаагчийн ажлаа дахиад хийв. Сарын дараа Хятад, Зөвлөлтийн бага хурлын дипломат товчооны дарга Ван Жаннины зөвлөхөөр ажиллах болсон учир байцаагчийн ажлаасаа татгалзав. Би Ван Жантинтай Өргөө болон Москва явахаасаа өмнө танилцсан байв. Зөвлөлтийн төлөөлөгчдийн тэргүүн нөхөр Давтыныд зориулж Бээжингийн төв паркт хийсэн зоог дээр би түүнтэй танилцсан билээ. Зоогийг Хятадын прарламентын гишүүн Ван Выпу зохион байгуулсан, Тэр бол миний сайн танил хүн бөгөөд намайг энэ зоогт урьсан билээ. Миний танил Ван Жинтин буюу доктор Ван намайг Гадаад Монгол явах гэж байгааг мэдэж байсан билээ. Түүнтэй нэгэн удаа уулзах үед Миний Өргөө явах гэж байгаа тухай асуудлыг хөндөж яриа үүсгэж билээ. Хятад, Зөвлөлтийн бага хурал дээр Гадаад Монголын асуудлыг хэлэлцэх гэж байсан учир доктор Ван Гадаад Монголын тухай асуудлыг ихэд сонирхож байсантай энэ нь холбоотой байжээ. Гадаад Монгол хэдэн цэрэгтэй вэ, эдийн засаг, улс төрийн байдал нь ямар байна вэ гэдэг асуудлыг Өргөөд очихдоо тодруулж ирэхийг надаас хүсч билээ. Түүний энэ хүсэлтийг биелүүлэе гэж би амалсан. Миний замын зардалд зориулж 500 хятад доллар надад өгсөн бөгөөд хэрэв даалгаврыг нь биелүүлбэл намайг Өргөөгөөс буцаж ирсэний дараа зөвлөхийн үүрэгт ажилд томилон ажиллуулна гэж амалж билээ.

Би Өргөөгөөс ирсэнийхээ дараа доктор Ванд зориулж Гадаад Монголын тухай тодорхой илтгэл бэлтгэсэн. Хожим энэ илтгэлийг нэлээд засварлаж “Шинэ Монгол” номондоо оруулсан. Гадаад Монголд консулын газрыг хамгаалагч хэсгээс өөр улаан арми байхгүй гэсэн миний мэдээллийг сонсоод Ван Жинтин тун дурамжхан байсан юм. Гадаад Монголын эдийн засаг, улс төрийн байдлын тухай миний тайланд ч тэр сэтгэл ханамжгүй байв.

Хэдийгээр миний мэдээлэлд тэрээр дурамжхан хандаж байсан боловч намайг хамгийн дээд зэргийн зөвлөхөөрөө авч ажиллуулсан билээ. Зөвлөх нэртэй боловч хэрэг дээрээ надад хийх ажил байсангүй, эхний сард 200,

хоёрдахь сард 100 хятад долларын цалин авсан боловч түүнээс хойш надад цалин ер өгсөнгүй, зөвлөх гэсэн нэртэй л үлдсэн юм. Би Бээжинд амьдарч байсан болохоороо монгол залуучуудын дунд хувьсгалт ажил зохиож эхлэв, Алтан буюу Дин Юынган, Цэрэндонров буюу Бай Юнти, Мандалт буюу Ли Фынгаин, Мөрөнга буюу Яау Зинтао зэрэг монголын улс төрийн зүтгэлтнүүдийн дунд эргэлдэх болов. Өргөөгөөс Бээжинд ирж сар болсоны дараа Гадаад Монголтой найрсаг харилцаа хөгжүүлэх талаар Баргын эрх баригчдад санал болгохоор Барга, Хайлаар хот явсан юм. Үүний хамт ардын хувьсгалт нам байгуулахын тулд монголын залуучуудын дунд хувьсгалт, зохион байгуулалтын нууц ажил явуулж байлаа. Барга ба Гадаад Монголын хооронд 1923 оны өвөл найрсаг харилцааны гэрээ байгуулагдсан нь миний ажлын нэг үр дүн болов. Ардын хувьсгалт намыг зохион байгуулах талаарх энэ үед миний хийсэн ажил нь уг үзэл санааг сурталчлан дэлгэрүүлэхэд чиглэгдэж байв. Би Хайлаарт нэг сар орчим болсоны дараа Бээжинд буцаж тэнд 1924 оны зун хүртэл хөдлөлгүй суув. Энэ үед Бээжинд “Шинэ Монгол” номоо хэвлүүлсэн юм. Зөвлөх нэрээ хүлээсэн хэвээр байхдаа монгол залуучууд, улс төрийн зүтгэлтнүүдийн дунд хувьсгалт ажлыг зохион байгуулсаар л байв. Зөвлөхийн албан тушаалын 300 хятад доллар, Ринчиновын өгсөн 1000 хятад долларын хүчээр л амь зууж байв.

1924 оны зун ямарч тусгай даалгаваргүйгээр Хайлаар хотод эргэн очсон юм. Хайлаарт ирмэгцээ Фуминтайтай хамтран хувьсгалт хэсэг байгуулж, түүний хуралдаанаар Фуминтайг сонгож Өргөөд томилон явуулав. Үүний хамт нөхөр Баигоро, Хасбаатар, Алинтай нарыг Өргөөд суралцуулахаар нууцаар явуулсан болно. Би өөрийн хоёрдахь хөвүүн Футу туны Гуйфуг дагуулан Нанжинд болсон Хятадын гэгээрүүлэгчдийн их хуралд зочноор оролцсон болно. Нанжинаас бид Шанхайд очсон, тэнд Жан ди, Юн ужен зэрэг Гоминьданы гишүүдтэй танилцсан. Гоминьдан намын төв Кантонд оч гэж тэд надад зөвлөсөн. Би хүүгийнхээ хамт Кантонд очсон, хоёр ч удаа Сун Ятсентай уулзсан. Кантонд хоёр долоо хоног болоод Хайлаарт 1924 оны намар буцаж ирсэн. Хайлаарт сар гаруй болохдоо Өргөөгөөс ирсэн Фуминтайтай уулзав. Фуминтай МАН-ын III их хуралд оролцож, Гадаад Монголын намын Төв Хороо манай Баргын хувьсгалт хэсгийг өөрийн намын бүрэлдэхүүн хэмээн үзэх шийдвэр гаргасан гэв. Фуминтайд тамга, анкет өгөөд Ардын Хувьсгалт Намын Баргын Хороог зохион байгуулахыг үүрэг болгожээ. Намайг Кантоноос ирэхээс өмнө Фуминтай зохион байгуулалтын ажлыг хийгээгүй байв. Намайг ирмэгц Фуминтай бид нар хамтран 20 хүн оролцсон зөвлөлгөөн зохион байгуулж, Ардын хувьсгалт намын Баргын Хороог сонгов. Үүнээс 7 хүнийг, тухайлбал, намайг даргаар, Адилбаярыг нарийн бичгийн даргаар, Фуминтай, Алтанбат, Мөнхгэрэл, Дынгуй, Хуалинтай нарыг гишүүнээр сонгожээ. Төв Хорооны сонгуулиас хойш хэдэн өдрийн дараа Мердин, Соёлтой, Хибало, Баянбаатар, Цагаанлам,

зэрэг 8 хүнийг Өргөөд суралцуулахаар явуулсан.

Есдүгээр сар орчимд би Өргөө явж Гадаад Монголын Ардын бүгд найрамдах улсын анхдугаар их хуралд оролцсон. Өргөөд сар орчим болоод Хайлаар хотод буцсан. Хайлаарт байхдаа Баргын хоршооны салбарыг өргөтгөх зэрэг хоршооны ажил төрлийг голлон хөөцөлдсөн, түүгээр дамжуулан олон түмний дунд намын ажлыг явуулж байлаа. Энэ үед би “Монголын ард түмний шийдвэр” гэсэн товхимол бичсэн. Түүнийг бичих ажлыг 1924 оны өвөл дуусгаж, Бээжинд нөхөр Фуминтайд явуулсан. Фуминтай энэ үед Бээжинд монголчуудын дунд намын зохион байгуулалтын ажил хийж байсан юм. Би 1925 оны намар Хайлаараас Бээжингээр дамжин Хаалганд очиж Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намын анхдугаар их хуралд оролцсон. Их хурал эхлэхийн өмнө би Хаалганд ирж бэлтгэл ажилд нь оролцсон. Их хурал 10 дугаар сарын 12-нд нээгдсэн. Их хурлаас ӨМАХН-ын Төв Хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй сонгосон. Намын даргаар Бай юнти Цэрэндондовыг, нарийн бичгийн даргаар намайг, гишүүдээр Фуминтай, Алтан, Мөрөнга, Мандалт, Сайнбаяр буюу Бао Юечин нарыг сонгожээ.

Би Хаалганд 1926 оны зун болтол байхдаа Төв Хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг хийсэн юм. Би 1926 оны хавар намын ажил зохиохоор хоёр сарын хугацаатай Бээжинд байсан. Төв Хорооны нарийн бичгийн даргаар Хаалганд ажиллаж байхдаа Фын Юсянтай холбоо тогтоож, түүний зөвлөхийн үүргийг гүйцэтгэж байв. Фын Юсяныг ухралт хийх үед буюу 1926 оны зун би Өргөөд очсон. Өргөөд сар гаруй болсоны дараа Баргад очихоор явж байгаад хил дээр ирэх үед намайг баривчлах тушаалыг Жан Золин гаргасан гэдгийг дуулаад Барга явахдаа больж Өргөө лүү буцсан. Өргөөд хоёр долоо хоног болсоны дараа Намын Төв Хорооныхоо ажлыг үргэлжлүүлэхээр Хаалган явсан. Намайг ирсэний дараа Төв Хороо Бугатад шилжихээс өөр аргагүй болсон учир би Төв Хорооны хамт Бугатад болон Өвөр Монголын Ордосын сеймд очсон. Бид Бугатад намын их хурал хийсэн, намын улс төрийн дээд сургуулийг зохион байгуулсан. Би 1926 оны өвөл балнадын хижгээр хоёр сар өвчлөв. Өвчтөн намайг Фын Юсяны ухарч буй армитай хамт авч явдаг байсан бөгөөд ийм маягаар Нинся хотод очоод байхдаа энэ өвчнөөсөө салсан билээ. Алшаагийн вангийн өргөө хавьцаа 1927 оны хавар намын ажил явуулж байгаад мөн оны зуны эхээр би Өргөө орохоор мордсон юм. Энэ үед ӨМАХН-ын Төв Хорооны ихэнх гишүүд Өргөөд цугларсан байв.

ӨМАХН-ын Төв Хороо Бугатад байрлаж байх үед Өвөр Монголын ардын армийг зохион байгуулсан юм. Арми нь ойролцоогоор 1000 хүнтэй байв. Цэргийн штабыг байгуулж даргаар нь Цэрэндонровыг (Бай Юнти) томилжээ.

Төв Хороо Өргөөд байрлаж байхдаа намын дотоод бүрэлдэхүүн,

намын тактикийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор бага хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн юм. Нөхөр Цэрэндонров энэ үед Нинся хотод байв. Хэрэв цахилгаан утас явуулсан бол тэрээр бага хуралд хүрэлцэн ирэх байв. Тэрээр бага хурлыг эхлээд хүлээн зөвшөөрөхгүй байсан боловч эцэстээ хүрч ирсэн юм. Өргөөд байсан АХН-ын гишүүд Бага хуралд оролцсон бөгөөд тэдний ихэнх нь суралцагч залуус байв. Энэ бага хурал дээр хагарал гарсан билээ. Нэг хэсэг нь Цэрэндонровын бодлогыг барьж байсан бол нөгөө хэсэг нь намайг дэмжив. Хятадад ардын засаг тогтсон тэр үед л Өвөр Монголын автономи боломжтой болно гэж Цэрэндонров үзэж байв. Өвөр Монголын автономийг чухамхүү өөрсдийн хүчээр босгох ёстой гэж би үзэж байсан юм. Намын ажил сул байна гэж Бага хурал үзээд Төв Хорооны хуучин тэргүүлэгчдийг татан буулгаж шинээр сонгох тогтоол гаргажээ. Төв Хорооны тэргүүлэгчдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов. Намын даргаар(2) нарийн бичгийн даргаар Хорлоог, гишүүдээр Арлон, (3), Баатар, Баянмандах, Фуминтай нарыг сонгожээ. Намайг сонгосонгүй.

Энэ үед Үйлдвэрчний эвлэлийн анхдугаар их хурал Гадаад Монголд болсон юм. Би Гадаад Монголын намын гишүүн учир намайг Үйлдвэрчний эвлэлийн Төв Зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн даргаар сонгов. Би энэ албыг 1928 оны хавар хүртэл хашсан билээ.

Энэ оны хавар Профинтерний 4 дүгээр конгресст намайг төлөөлөгчөөр оролцуулсан бөгөөд миний бие Профинтерний Төв Зөвлөлийн гишүүнээр сонгогдов Тэгээд би Өргөөд буцаж ирсэн.

Намайг конгресст явахын өмнөхөн ӨМАХН-ын Төв Хорооны даргын орлогчоор томилсон учир би Москвад байхдаа ӨМАХН-ын тухай илтгэлийг КИГХ-нд хийсэн, Нөхөр Бухарин намайг нэг удаа хүлээн авч уулзсан болно.

Москвад конгрест оролцож байхдаа уушигны үрэвслээр өвчилж, түүнийгээ эмчлүүлсэн. Өргөөд буцаж ирээд сарын амралтаа авч юу ч хийгээгүй.

ӨМАХН-ын Төв Хороо Баргад намын их хурал хуралдуулах тогтоолыг 1928 оны 6 дугаар сард гаргажээ. Энэ үед Жан Золиныг алсан хэрэг гарсан боловч их хурал хуралдуулна хэмээн Баргын намын нөхөд зүтгэсэн хэвээр байв. Их хурал хуралдуулах явдлыг Фуминтайд тусгайлан даалгасан ажээ. Барга ба Гадаад Монголын хил дээрх Ходир Болон гэдэг газарт намын их хурлыг хуралдуулахаар шийдвэрлэжээ. Өргөөд байсан ӨМАХН-ын нэртэй бүх гишүүд их хуралд оролцжээ. Би энэ үед Өргөөд байсан учир их хуралд оролцож чадаагүй. Их хурал болохоос өмнө Баргын фракцийн зөвлөлгөөн Өргөөд болсон бөгөөд түүнд надаас гадна Фуминтай, Эрхэмбат, Боширо, Өлзий нар оролцсон юм. Жан Золиныг алсантай холбогдон Манжуурт бий болсон нөхцөл байдлыг Баргын автономийн төлөө, ардын засгийг сэргээхийн төлөө гэсэн уриан дор зэвсэгт бослого гаргах хэрэгт ашиглах ёстой гэсэн

шийдвэрийг бид энэхүү зөвлөлгөөнөөр гаргасан юм. Үйл ажиллагааны төлөвлөгөөг их хурал шийдвэрлэх ёстой байв.

Миний эрүүл мэндэд цэвэр агаар хэрэгтэй байснаас гадна их хуралд оролцох хүсэлдээ автан хэсэг нөхдийн хамт Санбейст ирсэн боловч их хурал дууссан, Баргад зэвсэгт бослого гаргахад бэлтгэх тухай шийдвэрийг их хурлаас гаргасаныг Өргөөд буцаж явсан төлөөлөгч Эрхэмбатаас би мэдсэн юм.

Дээр дурдсан зүйлүүдийг миний хэлсэнээр зөв бичсэн байна, ийм учраас би гарын үсэг зурав. Орос хэл сайн мэднэ. Иймээс орчуулагч хэрэглээгүй болно (4).

Мерсе.

Мэдүүлэг авсан

Онцгой хэлтсийн 1 дүгээр салбарын даргын орлогч

Тайлбар:

1. Алс Дорнодын хязгаар нь Бүх Оросын Төвийн Гүйцэтгэх Хорооны 1926 оны 1 дүгээр сарын 4-ны өдрийн шийдвэрээр байгуулагдсан. Захигааны төв нь Хабаровск хот.

2. Нэр нь гаргагдаагүй.

3. Мөн нэр нь гаргагдаагүй.

4. Байцаалтын мэдүүлгийг орос хэл дээр гараар бичжээ.

Баримт № 2.

Нөхөр дарга танаа

1932 оны 9 дүгээр сарын 19.

Шоронгийн 8 дугаар өрөөнд сууж буй миний бие Тантай хийсэн ярилцлагын дараа, надад өгсөн сайхан ном, зөвлөлтийн сониныг уншсаны дараа оюун санаанд маань эргэлт гарсаныг мэдэрсэн, большевикууд Лениний онолыг хатуугаар, үнэн зөвөөр хэрэгжүүлж, социализмыг амжилттай байгуулж байгааг мэдэв. Японы империализмд үйлчлэхэд хүргэсэн өөрийн алдаатай үзэл бодол, буруу үйл ажиллагаагаа би одоо нэн тодорхой ухамсарлав. Ийм учраас энэхүү мэдэгдэлдээ өөрийн алдаагаа үнэн сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэхийн хамт Японы гар хөл болсоны шалтгааныг тодорхойлохыг эрмэлзсэн болно.

Би нийгмийн гарлын хувьд хөрөнгөтний хүрээллээс гаралтай, залуугаасаа тарчиг амьдралыг үзээгүй, хөрөнгөтний үзэл суртал бүхий боловсрол эзэмшсэн, Ленинизм, Марксизмын сургаалтай танилцаагүй болно. Суралцаж байх үеэсээ нэг талаар, хятадын империализмын зүгээс Монголыг үндэстний хувьд доромжлон гутааж буй явдлыг хүчтэй мэдэрсэн, нөгөө талаар, энэ мэдрэмж маань үзэн ядах үзэлд хүргэсэн, Юань гүрний

үеийн хүчирхэг Монголын баялаг амьдралыг судлах явцад үндэсний үзэлд тулгуурласан монголизмыг талархах үзэл бодол асар хүчтэй болсон юм.

Жан Зо-лин болон “Фусан” яамны зүгээс Монголыг эзэрхэн дарлах гэж байгааг ялангуяа 1921 онд хүчтэй мэдэрсэн бөгөөд чухамхүү тэр үед надад хувьсгалт үзэл санаа төрүүлсэн Хятадын хувьсгалт намын ном бүтээлийг олж авсан билээ. Нөхөр Ринчиновоос Хүрээнд хүрэлцэн ирэхийг урьсан нууц саналыг би 1923 онд хүлээж аваад Өргөөд болон Москва орж Монгол болон ЗХУ-ын хувьсгалт байгуулалтын амжилтыг өөрийн нүдээр харж үнэмшсэн, тэмцлийн үзлээр зэвсэглэж Өвөр Монголд хувьсгалт ажлыг эхлэн явуулсан юм. Коминтерний төлөөлөгч нөхөр Очирений тусламжтайгаар зөв удирдлагыг олсон, тэрээр жинхэнэ хувьсгалч хүн гэдгээ Ардын Хувьсгалт намын ажилтнуудад харуулсан билээ. (2)

Өвөр Монголын Ардын Хувьсгалт намд 1927 онд хагарал гарсаны дараа Гадаад Монголын Ардын Хувьсгалт намын дарга Дамбадоржийн (3) санал болгосон ёсоор Бүх Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв Зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдсон юм.

Өргөөд ажиллаж байхдаа нөхөр Дамбадоржийн оюун санааны нөлөөнд автагдаж байгаагаа би мэдэрч байсан юм. Дамбадорж тэр үед ЗХУ ба Коминтерний бодлогыг үнэлэх талаар барууны хэлбэрэл гаргасан бөгөөд тэрээр дараах үзлийг баримталж байжээ. Үүнд:

1. Монголын ард түмнүүд нэгдэх явдалд ЗХУ, Коминтерн саад учруулж байна.

2. Бие даасан байх, өөрийн дипломат бодлогоо явуулах боломжийг Гадаад Монголд олгохгүй байна.

3. Бие дааж эдийн засгаа хөгжүүлэх боломжийг (аливаа улс орнуудтай чөлөөтэй харилцах явдлыг) олгохгүй байна.

Нөгөө талаар миний ихэд хүндэтгэдэг, монголизмын эцэг, эрдэмтэн Жамсарановын нөлөө бас их байв. Түүний үзэл гэвэл:

1. Монголчууд нэгдэн нийлсэн цагтаа л төр улсаа байгуулж чадна.

2. Монгол орон ганцхан улсыг түшиглэх ёсгүй.

3. Монгол улс өөрийн далайн зогсоолтой байх зэрэг болно.

Ийм үзэл бодлын нөлөөгөөр ЗХУ, Коминтерний бодлогод итгэх явдалд эргэлзээ төрж, урьдын үндсэрхэх үзлийн хүмүүжил маань дахин сэргэсэн юм.

1928 оны эхний хагаст Монголын Үйлдвэрчний эвлэлийн нарийн бичгийн даргын хувьд Москвад болсон Профинтерний 4 дүгээр их хуралд оролцсон, ӨМАХН-ын Төв Хорооны орлогч даргын хувьд Коминтернд очиж нөхөр Бухаринтай уулзсан. Коминтерний зүгээс Өвөр Монголд идэвхтэй тусламж үзүүлэхгүй юм байна гэсэн сэтгэгдэл төрсөн. Тэр үед Афганистаны шах

Амануллаг ёс төртэйгөөр угтан авч байгаа явдал давхацсан, Монголын талаарх анхаарлаа сулруулж, капиталист орнууд, эзэн хаадыг ЗХУ дэмждэг юм байна гэсэн сэтгэгдэл төрүүлсэн юм.

Би тэр үед орос хэлээрх яриаг гадарладаг байсан боловч дараах асуудлууд тодорхой бус байв. 1). ЗХУ-ын гадаад бодлого, пролетарийн хувьсгалын зарчим, 2). Үндэсний асуудлаарх Ленин, Сталины үзэл бодрол, 3). БХКН-ын эгнээн дэх хагарлыг ойлгохгүй байсан, баруун ба зүүн хэмээсэн үзэл бодролын ялгаа байна, Лениний бодлого бол баруунтныг төлөөлж байна гэж ойлгож байсан учир ЗХУ, Коминтернд талархалтай хандах тухайд бүр ч их эргэлзэх болсон билээ.

Жан Зо-линыг 1928 оны зун алагдсаны дараа тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх эрмэлзлэл Баргын хүн ам, намын гишүүдийн дунд хүчтэй болов. Гадаад Монголын нам баруун ба зүүн гэсэн хоёр хэсэгт хуваагдан хагарах нь тодорхой болсон тэр үед би энэхүү улс төрийн эвдрэл маргаанд оролцохгүй байхыг хичээж, Баргын үйл явдлыг урагшлуулах, үүгээр дамжуулан Өвөр Монголын олон түмнийг босгоход нөлөөлөх ёстой гэж шийдвэрлэсэн юм. Ийм учраас Коминтерний зөвшөөрлийг хүлээлгүйгээр тэмцлийн ийм замд би өөрөө дур мэдэн орсон болой. Баргад бослого гаргахдаа ЗХУ ба Гадаад Монголын зүгээс тусламж авч чадахгүй гэдэгт би итгэлтэй байсан. Харин япончууд энэ үед ШАО-ЛИНЫ төлөөлөгчийг ирүүлсэн, тэдний тусламж дэмжлэгийг авахаас өөр аргагүй байсан учир өөрийн нөхцлөө бичгээр илэрхийлж ШАО-линаар дамжуулан япончуудад хүргүүлсэн билээ. Гэвч үүний хариуг авахаас өмнө Баргын үйл явдал бүтэлгүйтэн дарагдсан, Өргөөд буцаж очиж болохгүй гэдгийг би мэдэрч байсан, хэрэв буцаж очвол Гадаад Монголын нам, Коминтернээс би шийтгэл хүлээх байлаа. Ийм учраас би Жан Сюе ляны талд орсон юм.

Намайг Мүгдэнд амьдарч байх үед Өвөр Монгол орон Японы хүчтэй нөлөөнд автагдсан нь тодорхой болсон, япончууд энэ зорилгоо хэрэгжүүлэхдээ хэн бүхнээс илүүтэйгээр монголын хүн амыг дарлан мөлжиж байсан хятадын милитаристуудыг ашиглаж байв. Хоёр дарлагчтай байснаас ганц дарлагчтай байсан нь дээр гэж би тэр үед бодож байснаас гадна үндэсний хувьсгалт тэмцэл хийх хүсэл зориг хэвээр байсан, гадны тусламжгүйгээр энэ хэрэг бүтэхгүйг бас ойлгож байсан юм. 1928 оноос хойш (Баргын үйл явдлын дараа) Гадаад Монгол болон ЗХУ-аас Өвөр Монголд тусламж үзүүлнэ гэдэгт найдах хэрэггүй болсон, ганц гарц үлдсэн, тэр нь Японы тусламжийг ашиглах явдал байв. Энэ нь Өвөр Монголыг Японд ойртуулах санааг надад төрүүлсэн, ноёд лам нар, цэргийнхэн, сэхээтнүүд, суралцагсад зэрэг өөртөө талархалтай хандагч олон хүнийг япончууд талдаа татсан байв. Баргын 1928 оны үйл явдлын дараа намайг өөртөө татах гэсэн шууд болон шууд бус шинжтэй оролдлогыг япончууд хийх болсон бөгөөд би Монголын эрх ашгийн төлөө ажиллаж байна гэж итгэж байсан боловч

хэрэг дээрээ японы империализмд үйлчлэхэд хүрсэн ажээ.

Дээр дурдсан зүйл нь үзэл бодолоо хэрхэн яаж өөрчилсөн, японы гар хөл яагаад болсон зэргийн шалтгааныг нээн харуулж байна.

Тэхээр би уучилж болшгүй том гэмт хэрэг үйлдсэнээ ухамсарлаж байна. Монголын дотоодод “Нармай монгол”, “Япон-Монголын найрсаг харилцаа” гэх зэрэг ухуулга хүчтэй болсон, “язгууртны үзэл”, “ламын ёс”, “их гүрний түүхэн шовинизм” зэрэг нь олон түмэнд хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд тэдгээр нь хувьсгалт үзэл санааг хүлээн авах хөрс суурийг үгүй болгож байна.

ЗХУ-д социализмыг яаж байгуулж ирсэнийг, Зөвлөлтийн үндэстэн ястнууд аз жаргалтай сайхан амьдралаа хэрхэн бүтээн босгосныг Өвөр Монголын ард түмэн мэдэхгүй байгаа төдийгүй, Гадаад Монголыг чөлөөлсөн явдал бол үндэстний мөхлийн эхлэл хэмээн үзэж байна.

Дээр дурдсан зүйлүүд нь Өвөр Монголд зориулсан ном бүтээлийг туурвих шаардлагатайг харуулж байна. Тэдгээр нь Гадаад Монгол ба ЗХУ дахь бодит байдлыг тайлбарлах, Өвөр Монголд хувьсгалт үзэл санааг дэлгэрүүлэхэд түлхэц үзүүлэх, Японы империализмын хортой ухуулгыг няцаах, Монгол дахь түүний хүч чадлыг сулруулах, Өвөр Монголын хоцрогдсон хортой ахуйн нөхцлийг эвдэхэд чиглэгдсэн байх ёстой. Энэ үндсэн дээр Японы империализмыг эсэргүүцсэн Зөвлөлтийн эрх ашгийг хамгаалах хэрэгт Өвөр Монголыг ойртуулах ёстой юм.

Энэ салбарын ажил үйлсэд ашиг тус үзүүлж чадна гэж би өөрийгөө үзэж байна. Миний бие гэмт хэрэг үйлдсэнээ ухамсарлахын хамт өөрийн төөрөгдлийн жинхэнэ шалтгааныг чин сэтгэлээсээ илэрхийлсэн болно. Ийм учраас миний шийтгэлийг хөнгөвчлөх талаар тусламж үзүүлэхийг нөхөр Дарга Танд хүсэлт болгож байна. Хувьсгалын ашиг тусын төлөө, ард түмнийхөө төлөө тустай зүйл хийнэ гэдгийг би ажил хэргээрээ нотолж чадна, ингэж би гэмээ арилгана. Танд ямагт талархалтай хандахаа илэрхийлсэн

МЕРСЕ.

ОХУ-ын Холбооны Аюулгүй байдлын төв архив.

Хавтаст хэрэг № Р-34587, хуудас 31-33.

Тайлбар:

1. Эхний хуудасны дээд өнцөгт “хятад хэлнээс орчуулсан” гэсэн тайлбар байна. Мэрсээгийн энэхүү бичгийг орос хэл дээр бичгийн машинаар үйлджээ.

2. ӨМАХН-ын дэргэд ажиллаж байсан Коминтерний төлөөлөгч

Очировыг хэлж байна.

3. МАХН-ын Төв Хорооны дарга Д.Дамбадоржийг хэлж байна.

Хабаровск хот

1933 оны 1 дүгээр сарын 18.

АЛС ДОРНОДЫН ХЯЗГААРЫН
УЛС ТӨРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТ

Хоригдол Мэрсээгээс,

Намайг мөрдөн байцаасны эцэст Японы тагнуул, улс төрийн хутган үймүүлэгч хэмээх ялыг надад тулгав. Хэрэв ийм ялыг 6-7 сарын өмнө буюу Зөвлөлт байгууллын нөхцөл байдалд дасаагүй, пролетарийн тэмцлийн зоримлтыг ойлгоогүй (нөхөдтэйгээ хийсэн ярилцлага, сонин уншлага, улс төрийн ном зохиол, ялангуяа нөхөр Сталины сүүлчийн хэлсэн үгтэй танилцсан зэрэг нь надад их тус болсон) байсан учраас монголын ард түмнийг чөлөөлөхийн төлөө тэмцэж буй намайг тагнуул хэмээн яллаж байгааг ойлгохгүй, ийм ял бол хүчирхийллийн илрэл хэмээн үзэх байв. Харин одоо бол гэмт явдал, улс төрийн алдаагаа болон үндэсний хөдөлгөөнийг удирдах талаарх чиг баримтлал буруу болохыг ухамсарласан, энэ бүхний тухай үнэн сэтгэлээсээ ярьсан болно. (Өнгөрсөн оны зунаас эхлэн мөрдөн байцаалтад би огт өөрөөр хандах болсон нь үүнээс ойлгомжтой болно).

Өвөр Монголын Ардын хувьсгалт намыг удирдахдаа өөрийнхөө зорилтыг хэрхэн ойлгож байсныгаа, янз бүрийн бүлгүүдтэй хамтран ажиллаж дээрх зорилтуудаа хэрхэн хэрэгжүүлсэнийг, Коминтерний удирдлагаас холдож, японы тагнуул гэж хэлэгдэхэд хүрсэн зэргийгээ юу ч нуугаагүй юм.

Япончуудтай тогтоосон хэлхээ холбооны тухай бүх зүйлийг ярихгүй байна, Японы ажил хэрэгч бүлгийнхнээс авсан даалгавраа нэгийг нь ч биелүүлээгүй мэт мэдүүлэг өгч байна хэмээн надтай хийсэн ярилцлага, байцаалтын үеэр надад хэлж байв. Ийм учраас дараах тайлбар хийх явдлыг өөрийн үүрэг хэмээн үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Японы бүрэн нөлөөнд байгаа Жан Золингийн эсрэг, монгол ноёдын харгис хэсгийн эсрэг ил шууд тэмцдэг Ардын Хувьсгалт Намыг зохион байгуулагчдын нэг нь миний бие болно.

Хоёрдугаарт, Өвөр Монголын АХН-ыг задлан бутаргахыг япончууд хөхүүлэн дэмжиж байсан бөгөөд энэ нам задарсаны (1927) дараа би энэ намынхаа эгнээнд хэвээр үлдсэн, шинэ сонгогдсон Төв Хорооны орлогч даргаар ажиллаж байв.

Гуравдугаарт, 1928 оны Баргын бослого гарах хүртэлх хугацаанд би Бүх Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв Зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажилласан, Хүрээнд амьдран сууж байсан, Москвад болсон Профинтерний

4 дүгээр их хуралд оролцсон. Өөрөөр хэлбэл Зөвлөлтийн талыг баримталж байсан бөгөөд Японы төлөөлөгчидтэй ямар ч холбоо барьж байгаагүй.

Ийм учраас Баргын нөхцөл байдал нь ЗХУ болон Гадаад Монголын зүгээс тусламж үзүүлэхээс татгалзсантай холбогдон аргагүй байдалд орж бослого гаргагчдад тусламж үзүүлэхийг амалсан Японы төлөөлөгчдийн саналыг хүлээж авахаас өөр аргагүй байдалд хүргэсэн юм. Японы ашиг сонирхолд миний ойртсон явдлыг эхлээд болгоомжтой судалж эхэлсэн, харин жирийн тагнуул болгож намайг ашиглах гэж эрмэлзсэнгүй. Монгол дахь Японы байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн соёлын болон улс төрийн томоохон арга хэмжээнүүдийг зохиоход миний нэр төр, хүч, хэлхээ холбоог ашиглахыг гол болгожээ. Ийм учраас миний ажил нь

- а). Японыг баримтлагч боловсон хүчнийг бэлтгэх,
- б). Монголын ноёдтой залуучуудын тогтоосон найрамдлыг бэхжүүлэх,
- в). “Монгол соёлын төвүүд”, “сейм ба хошууны хороод” гэх мэтийн монгол ноёдын ашиг сонирхлыг бэхжүүлсэн холбоодыг зохион байгуулах,
- г). Залуучуудыг Японд талархалтай болгох,
- д). “Нармай Монгол” гэх мэтийг дээдэлдэг үндсэрхэх үзлийг өдөөх зэрэг болно.

Японы төлөөлөгчид намайг ашиглахаас эхний үед болгоомжилж байсан юм. Энэ нь миний бие Японыг эсэргүүцэгч Жан сюэлиний кабинеттай холбоотой байснаар бас тайлбарлаж болно. Би Жан Сюэлиний зөвлөхөөр ажиллаж байсан боловч надад тэрээр илэн далангүй хандаж байсангүй, харин ч сүрхий хянаж цагддаг байсан юм.

Японы төлөөлөгчдөөс хэдэн удаа ямар хэмжээний зүйл авсаныгаа яагаад мэдүүлэхгүй байна вэ гэж надаас асуудаг байв. Тагнуулын шинжтэй жижиг даалгавар авч биелүүлж байсангүй, Японыг баримталсан арга хэмжээг зохиохдоо япончуудаас мөнгө төгрөг нэхэж байгаагүй. Өвөр Монголын АХН-ын 2 дугаар их хурлыг хуралдуулахтай холбогдуулан би мөнгөний тухай асуудлыг нэг удаа дэвшүүлсэн боловч надад мөнгө өгөөгүй, би ч Хятад руу явсан билээ.

Энэ бүхэн бол өнгөрсөн хэрэг юм. Харин одоо бол төөрөлдсөн гэмт явдлаа хүлээсэн, аргаа барахдаа бүхнийг илчлэн ярьж нүглээ наманчилсан хүн Таны өмнө зогсож байна. Миний хувь заяа шийдэгдэж байгаа асуудлын өмнө, өнөө үеийн өмнө би зогсож байна. Би өөрийгөө дахин төрсөн мэтээр бодож байна, дарлагдсан олон түмнийг чөлөөлөхийн төлөө пролетарч санаа сэтгэлээр ажиллана гэдгээ илэрхийлж байна. Таны байгаа энэ газарт, эсвэл Монголд, хаа ч байсан, ямар ч нөхцөлд ажил хэрэгт тань тус болно гэдэг

өөрийн хүсэл, хувийн баталгаа гаргахаас өөр юм надад алга. Би хувьсгалт ёсоор үр ашигтай байхыг хүсч байна, тийм ч байж чадна, үүнийг ажил хэргээр нотлон харуулах боломжийг надад олгохыг Танаас хүсч байна.

Мөрдөн байцаалт дуусч алив асуудал тодорхой болсон, би ч бичиж өгсөн болохоор одоо би улс төрийн ном зохиол, сонин унших, орос хэл судлах ажил хийж байна. Өвөр Монгол болон Баргын ахуйд наад захын улс төрийн ном бүтээл ихэд дутагдаж буйг харгалзан тэднийг оюун санааны талаар хувьсгалжуулах эрх ашгийн үүднээс дагуур, монгол, хятад хэл дээр цагаан толгой, хэлний зүй, улс төрийн толь зэргийг бичих бэлтгэл ажилд орох, цаашдаа дээрх зорилгоор сурталчилгааны ном бүтээл бичих боломжийг надад олгохыг Танаас хүсч байна.

Хэрэв Та надад зөвшөөрөл олговол Маркс, Лениний сургаал, Коммунист тунхаг, Коминтерний программ, БХКБН-ын программ, Ленинизмийн асуудлууд, Марксизмын бүтээлүүд зэрэгтэй нарийвчлан танилцах боломжоор хангахыг Танаас хүсч байна. Үүнээс гадна Орос, хятад толь ашиглах зөвшөөрөл олгох, миний төлөвлөж буй ажлын чиглэлээр удирдлага, заавар өгөх нөхрийг гаргаж ажиллуулахыг хүсье.

Урьд өмнө үндэсний чөлөөлөх тэмцэлд хүчээ өгч байсны нэгэн адил одоо ч гэсэн ганц өөрийн биеийг бодож байгаа бус харин нүглээ наманчилсанаараа сэтгэл санааны хувьд тайвширч, ажил хөдөлмөрөөр өөрийн алдаагаа засч залруулахыг хүсч байна.

МЕРСЕ

ОХУ-ын Холбооны Аюулгүй Байдлын Албаны төв архив

Хавтаст хэрэг № Р – 34587, хуудас 142-144.

Тайлбар:

1. Мэдэгдлийн эцэст монгол үсгээр Мэрсээ, кирилл үсгээр Мерсе гэж гарын үсэг зуржээ.

2. Гарын үсгийн дор нь “энэхүү мэдэгдлийг Мэрсээгийн хүссэнээр бичсэн” гэсэн тайлбар хийжээ.

3. Мэдэгдлийг орос хэл дээр бичгийн машинаар бичжээ.

1933 оны 11 дүгээр сарын 20.

Лхүмбийн хэрэгтэй холбогдуулан нэмэлт болгож дараах зүйлийг өгүүлье.

Инокучи хэмээх япон хүн бол Монгол дахь японы нэртэй тагнуулчдын нэг гэдгийг би өмнөх мэдүүлэгтээ тэмдэглэсэн. Тэрээр хэсэг япончуудыг толгойлон 1925 онд БНМАУ-ын зүүн хилээр нэвтрэх гэж байгаад Монголын хилчдэд баригдаж Улаанбаатар дахь Дотоодыг хамгаалах газрын хонгилд хоригдсон тэр үеэс би түүнийг мэдэх болсон юм.

Хаалганд 1925 оны 10 дугаар сард ӨМАХН-ын анхдугаар их хурал болсон бөгөөд түүнд МАХН-ын Төв Хорооны дарга Дамбадорж тусгай урилгын дагуу ирж оролцсон. Фын юй-сян түүнийг халуун дотноор угтаж авсан бөгөөд ерөнхий адьютант Чисон Юньжун, Хаалган дахь дипломат товчооны дарга Боу ши-зе зэрэг Фын юй-сяны гарын хүмүүс Дамбадоржид дээд зэргээр үйлчилсэн юм. Ба юн-ти (Ван зин-вей зэрэг санаа нэгтнүүд) бид хэд их хурлыг зохион байгуулагчийн хувьд бас Дамбадоржийг тойрон эргэлдэж, хятадуудтай хэлэлцээр хийхэд нь орчуулагчийн үүрэг гүйцэтгэж байлаа.

Нэг удаагийн уулзалт дээр Боу ши-зе БНМАУ-д санаандгүй нэвтэрсэн японы жуулчдыг баривчилсан тухай асуултыг Дамбадоржид тавьж, тэднийг суллах хүсэлтийг Хаалган дахь Японы консулын нэрийн өмнөөс гаргасан байна.

Дамбадорж 50 000 мексик долларын төлөөсөөр асуудлыг шийдвэрлэхийг зөвшөөрсөн ажээ. Энэ мөнгийг япончууд дипломат товчоонд хүргүүлсэн, түүнийг цаашдаа хэрхэн хуваарилсаныг би мэдэхгүй. Ямарч л байсан энэ хэдэн япончуудыг авахаар 1925 оны эцэст Улаанбаатар луу машин явуулсан юмдаг.

Би Фуминтайгаар дамжуулж Инокучитай харилцаж байсан, харин 1931 онд Хайлаарт түүнтэй нэг удаа уулзаж ярилцсан. Фуминтай Дамбадоржтой сайн танил байсан, ӨМАХН-ын анхдугаар их хурлын дараа энэ намын Төв Хорооны төлөөлөгчөөр Улаанбаатарт МАХН-ын Төв Хорооны дэргэд ажиллаж байв. Тэрээр 1925 оны хавар гэхэд Улаанбаатарт очсон, дараа нь Баргад буцаж иржээ. Фуминтай энэ үед Японы талд тагнуулын ажил хийгээгүй. Фуминтай 1926 оны зун Манжуур дахь Японы консулыг (нэрийг нь мартжээ) БНМАУ-д очуулах талаар Дамбадоржоос зөвшөөрөл авч чаджээ. Гэвч зохих газраас эсэргүүцсэн учир Японы консул Монголд очиж чадаагүй.

Фуминтай Мурасиматай хамт Хиагтаар дамжин БНМАУ-д очихоор 1927 онд Дээд-Үдэд очсон авч үнэмлэх бичиг олгоогүй учир Троицкосавскаас буцахаас өөр аргагүй болжээ. Энэ бол миний бодлоор БНМАУ-д нэвтрэх

гэсэн япончуудын эцсийн ил тод оролдлого байсан юм.

Жабальдишнаар дамжуулж Нунхэйжав болон Лхүмбэтэй харилцаж байсныгаа би өмнөх мэдүүлэгтээ дурдсан. Гэвч харилцаа холбоо маш нууц байдалд явагдаж байсан болохоор Жабальдишна тэр болгон хилээр чөлөөтэй нэвтэрч чадахгүй байсан юм. Ийм учраас Эрхэмбаярыг нэмэлт холбоочин бөгөөд агент болгож Нунхэйжав элсүүлж авсан ажээ. (Эрхэмбаяр бол 1910 оны хятадыг эсэргүүцсэн хөдөлгөөний удирдагч бөгөөд хожим Гадаад Монголын “бээс” хэргэм хүртсэн Тогтох тайжийн ач хүү болно). Үүнээс болж Эрхэмбаяр МАХН-ын хоёрдугаар цэвэрлэгээний үеэр 1929 онд намаас хөөгдөж нэг хэсэг ажилгүй байсан ажээ. Нунхэйжав түүнийг 1930 онд Өндөрхаанд явуулсан, өөрийн хамаатан болох өвөр монгол Бадрахын (Хуа-ин-куй) дэмжлэгтэйгээр тээврийн газарт орчуулагчийн ажилд орж, Манжууртай холбоо барих дамжуулга цэгийн үүргийг гүйцэтгэж байжээ.

Эрхэмбаяр 1931 онд Баянтүмэнд (Санбэйс) шилжсэн бөгөөд Нунхэйжав баривчлагдсаныг сонсоод илчлэгдэхээсээ айж Баргад зугатан очихоор шийджээ. Эрхэмбаяр 1931 оны 10 дугаар сард Дотоодыг Хамгаалах Газрын орон нутгийн нэгэн сургагч-буриад хүнийг (нэрийг нь санахгүй байна) өөртөө элсүүлж аваад түүний тусламжтайгаар Баргад, Хайлаар хотод зугатаж гарчээ. Эрхэмбаяр Хайлаарт ирмэгцээ Фуминтайтай уулзаж, авч ирсэн материалаа Фуминтайгаар дамжуулан Инокучид өгчээ. Би бас Эрхэмбаяртай уулзсан, тэрээр БНМАУ-аас зугатан гарсан тухайгаа надад ярьсан.

БНМАУ дахь манай ажилд асар их хохирол учрав (Нунхэйжав баривчлагдсан, Эрхэмбаяр зугатаж гарсан, бусад агентуудтай холбоо тасарсан зэрэг) гэсэн дүгнэлтэд Эрхэмбаярын ярьсан зүйлд үндэслэн Фуминтай бид хоёр хүрсэн бөгөөд БНМАУ-д цаашид зохиох ажлын төлөвлөгөөг Инокучитай хамтран яаралтай боловсруулахаар шийдвэрлэсэн болно.

Удалгүй намайг ЗХУ-д аваачсан тул энэхүү төлөвлөгөөг боловсруулахад би оролцож чадаагүй. Надаас хойш Фуминтай, Инокучи, бусад хүмүүс БНМАУ-ыг тагнах, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх талаар ямар ч ажил хийгээгүй гэдэгт би эргэлзэхгүй байна.

Би дараагийнхаа мэдүүлэгт 1931-1932 онд япончуудаас БНМАУ-ыг эзлэх талаар ямар зүйл төлөвлөж байсныг ярьж өгнө.

Миний мэдүүлгийг үнэн зөв бичиж надад уншиж өгсөн болно.

ОХУ-ын Аюулгүй Байдлын Албаны төв архив.

Хавтаст хэрэг Р-34587, хуудас 157-158.

Тайлбар:

1. Мэдүүлгийн эцэст монгол үсгээр Мэрсээ, кирилл үсгээр Мерсе гэж, хятад үсгээр Го Дао фу гэж гарын үсгээ зурсан байна.

2. Байцаалтын тэмдэглэлийг орос хэл дээр гараар бичжээ.

Баримт № 5. ЯЛЫН ДҮГНЭЛТ

БАТЛАВ

АДХ-ын УТНУГ-ын БЭТГ-ын орлогч

Мөрдөн байцаалтын № ... хэргийн дагуу

Мэрсээ буюу Го Дао фуд Эрүүгийн

хуулийн 58-ын 4, 58-ын 6 дугаар

зүйлүүдээр ял оноосон тухай

Дагуур-монгол Мэрсээ буюу Го Даофу монголчуудын үндэсний хөдөлгөөнийг өдөөн турхирч, Японы тагнуулын газрын даалгавраар Өвөр Монголын хэмжээнд өргөн хүрээтэй тагнуулын болон өдөөн хатгах ажил явуулж иржээ.

ЗХУ-ыг Японы эсрэг зэвсэгт мөргөлдөөнд өдөөн хатгах зорилгоор Манжуур өртөөн дэх Зөвлөлтийн консулын газарт 1931 оны 12 дугаар сарын 11-нд ирсэн Мэрсээг нууцаар баривчилж, Бүрэн эрхт төлөөлөгчийн газарт аваачжээ. Хэргийг мөрдөн байцааж дараах зүйлийг тогтоожээ. Үүнд:

Мэрсээ Гадаад харилцааны яамны дэргэдэх Бээжингийн дээд сургуулийн орос хэлний факультетэд 2 жил суралцсанахаа дараа Монголын хувь заяаг сонирхдогийн хувьд 1917 онд төрсөн нутаг Баргадаа буцжээ.

Үндсэрхэх-шовинист үзэлтэй, “Нармай монголын” болон “Баргын автономын” талыг тууштай баримтлагч Мэрсээ өөрийн ах ФУМИНТАЙТАЙ хамтран үндэсний боловсон хүчин бэлтгэх ажлыг идэвхтэй гүйцэтгэж эхэлсэн бөгөөд энэ зорилгоор Хайлаар хотод болон Мэхэрт хэмээх өөрийн тосгондоомонголын бага сургуулиудыг байгуулжээ.

Зөвлөлт засгийг эсэргүүцсэн өөрийн тэмцэлд бури адуудыг татан оролцуулах зорилгоор Дээд-Үд хотод 1918 онд атаман СЕМЕНОВЫН зохион байгуулсан Буриад-Монголын төлөөлөгчдийн их хуралд тэрээр идэвхтэй оролцжээ. Мэрсээ их хуралд оролцох үедээ РИНЧИНОВ, САМПИЛОН зэрэг үндэсний үзэлтнүүдтэй танилцаж, буриад болон монголчуудын дунд үндэсний ажил зохион байгуулахаар тэдэнтэй тохиролцжээ.

Мэрсээ 1923 онд урилгаар Өргөөд очихоор шийдвэрлэсэн бөгөөд эхлээд Бээжин хотод очиж Зөвлөлт-Хятадын Бага хурлын дарга ВАН ЖЕН-ТИНИЙ зөвлөхийн албыг гүйцэтгэх болжээ. Өргөөд албан ёсны шугамаар хүрэлцэн очих явдлыг Ван Жен-тин зохион байгуулж, Гадаад Монголтой холбоотой

түүний сонирхож байгаа асуудлуудыг тодруулах даалгаврыг түүнд өгчээ. Энэ үйл явдлыг Мэрсээ дараах байдлаар тайлбарлажээ.

Үүнд: "...Өргөөд очоод зөвлөлтийн цэрэг Гадаад Монголд байгаа эсэх, байгаа бол хэдэн цэрэгтэйг, түүнчлэн Гадаад Монголын эдийн засаг, улс төрийн байдлыг тодруулахыг Ван жен-тин надад үүрэг болгосон... Ван Жен-тины үүргийг биелүүлэхээ би зөвшөөрсөн, миний замын зардалд зориулж 500 хятад долларыг надад өгсөн" гэжээ. (Хуудас 18)

Өргөөд байгаагүй учир Ван Жен-тинд шаардлагатай мэдээллийг Мэрсээ цуглуулсаныхаа дараа Ринчиновын араас Москва явжээ. Буцах замдаа галт тэргэнд Хятадад суух ЗХУ-ын Бүрэн эрхт төлөөлөгч танилцаж, Бээжинд байх үедээ суралцагч монгол залуучуудын дунд үндэсний ажил зохион байгуулахаар РИНЧИНОВТОЙ тохиролцож, энэ ажилд зарлагадах 1000 хятад долларыг түүнээс авчээ

Мэрсээ Бээжинд очоод илтгэл бичиж өгчээ. Түүнд:

"...Би Бээжинд ирээд гүйцэтгэсэн ажлаа илтгэв. Тэрээр миний илтгэлийг сонсоод илтгэлийг бичиж өгөхдөө Гадаад Монголтой тогтоосон ЗХУ-ын харилцаа болон Гадаад Монголоос Хятадтай харилцаж ирсэн байдлыг тодруулахыг үүрэг болгосон юм гэжээ. (Хуудас 19).

Би ВАН ЖЕН-ТИНЫ дэргэд ажиллахдаа Бээжинд амьдардаг монголын үндсэрхэх үзэлтнүүдтэй уулзалдах болж, улмаар тэдний "Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам" гэдэг байгууллагын ажилд оролцож эхэлсэн, 1925 онд Хаалганд болсон зохион байгуулах их хурлаар Төв Хорооны нарийн бичгийн даргаар сонгогдсон, япончуудтай ойрын харилцаатай БАЙЮНТИ, АЛТАН, МАНДАХ зэрэг хүмүүс Төв Хорооны бүрэлдэхүүнд оржээ.

1927 оноос Төв Хорооны дотоодод санал зөрөлдөөн гарсан бөгөөд тэр нь Мэрсээ болон Байюнтигийн хоорондын үзэл бодлоор тодорхойлогдож байв. Намын отрядууд Фын Юй-сяны ардын армитай хамтран ажиллаж Өвөр Монголын сейм, хошуудад эзлэн авсан нутагт автономи тогтоох тухай тусгай бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэж Мэрсээ үзэж байв. Харин Мэрсээгийн энэхүү үзэл, үйлдлийг Төв Хорооны дарга БАЙЮНТИ шүүмжилсэн юм. Өргөөд болсон Ардын Хувьсгалт Намын онц хурлын шийдвэрээр Мэрсээг Төв Хорооны бүрэлдэхүүнээс гаргажээ. Мэрсээ Монголын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн даргаар томилогдон ажиллажээ. Энэ үеэс эхлэн Мэрсээгийн цаг зуурын хувьсгалт хөөрөлтийн байдал нь мэдэгдэхүйц буурч, Гадаад Монголын АХН-ын дарга, барууны хэлбэрэлтэн Дамбадоржийн дэмжин хөхүүлж байсан ажилд итгэл алдрахад хүрсэн юм. Энэ үеийнхээ сэтгэл санааны байдлыг Мэрсээ дараах байдлаар тодорхойлжээ.

"...Өргөөд ажиллаж байхдаа Дамбадоржийн оюун санааны нөлөөг би мэдэрч байсан, тэрээр Коминтерн, ЗХУ-ын бодлогыг үнэлэх талаар барууны хэлбэрэл гаргаж байсан" гэжээ (хуудас 31).

Өргөөгийн намын бага хурлаас сонгогдсон Төв Хороо ажиллах чадвар муутай байсан учир Мэрсээг Төв Хорооны бүрэлдэхүүнд дахин оруулсан бөгөөд тэрээр 1928 онд Москвад болсон Профинтерний 4 дүгээр их хуралд оролцохын хамт “Өвөр Монголын АХН-ын байдлын тухай” хэмээх илтгэлийг Коминтерний Гүйцэтгэх Хороонд тавьжээ

Москвад байсан тухайгаа Мэрсээ бичихдээ:

“...Коминтерний зүгээс Өвөр Монголд идэвхтэй тусламж үзүүлэхгүй байгаа мэт сэтгэгдэл төрсөн,...нөгөө талаар “нармай монголын” үзэл санааны эцэг, миний ихэд хүндэтгэдэг Жамцароногийн нөлөөгөөр Коминтерн, ЗХУ-ын бодлогод итгэх талаар надад эргэлзээ төрөх болж урьд өмнө олсон үндсэрхэх хүмүүжил маань дахин давамгайлж эхэлсэн” гэжээ (хуудас 32).

Коминтерний удирдлагатай харилцаагаа таслахаар хатуу шийдсэн Мэрсээ Өргөөд буцаж ирээд Манжуурт Жан Золиныг алсан ба япончуудын зохион байгуулсанаар Баргад үндэсний хөдөлгөөн өрнөхийн хамт ажлаа хаян Баргад гарч 1928 оны 8 дугаар сард тэнд бослого гаргажээ.

“...Би Баргын үйл явдлыг урагшлууж түлхэхийг хүссэн бөгөөд ... Коминтернээс зөвшөөрөл хүлээлгүйгээр тэмцлийн ийм замд дур мэдэн орсон” гэж Мэрсээ бичжээ (хуудас 32).

Мүгдэний цэргийг Манжуурт оруулсан үйл явдлаас олны анхаарлыг хөндийрүүлэх хэрэгт Баргын бослогыг ашиглах сонирхолтой япончууд өөрийн тагнуулын агент ШАОЛИН, НЯМЖАВ нараар дамжуулан Мэрсээтэй холбоо тогтоож, түүнд зэвсгийн тусламж үзүүлэхийг амалжээ. Мэрсээ энэхүү тусламжийг хүлээж суух завсраа бослогыг зогсоохыг шаардсан ЖАН СЮЕ-ЛЯНЫ төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж байснаас гадна Хятадын цэргийн отрядуудтай тулалдах Мэрсээгийн бодлогод босогчдын штаб шүүмжлэлтэй хандсан ажээ. Босогчид бүрэн ялагдал хүлээж, “Мэрсээгийн төлөвлөгөө” ч нуран унажээ. Мэрсээ Хүрээнд буцахаас айж байсан учир ЖАН СЮЕ-ЛЯНЫ талд орж зөвлөхөөр ажиллах болсоноор японы тагнуулын газартай ойр холбоо тогтоожээ.

Мэрсээ ярихдаа: “...Би Хятадын төлөөлөгчидтэй хамт Мүгдэн явсан. Энэ галт тэргэнд ШАОЛИН, НЯМЖАВ нар явж байсан. Хайлаарт тэднтэй би юу ч яриагүй” гэжээ (хуудас 13).

Хэд хоногийн дараа Мэрсээтэй уулзах зорилгоор Хаалганаас “Монголын асуудлаар мэргэжсэн” япон МУРУСИМА Мүгдэнд тусгайлан хүч иржээ. МУРУСИМАТАЙ Мэрсээг танилцуулах ажлыг ШАОЛИН зохион байгуулжээ. Мурусимагаас авсан даалгаврынхаа тухай Мэрсээ өгүүлэхдээ: “...монголын ноёдын эсрэг тэмцлээ би зогсоох ёстой болсон. Үндэсний хөдөлгөөн нь ангиар нь худаах явдлаар бус харин нэгдсэн фронтоор явах болсон юм” гэжээ (Мэрсээгийн мэдүүлэг хуудас 15).

Мэрсээ энэхүү даалгаврын хэрэгжүүлэх явдлыг өдөр тутмын ажилдаа

мөрдлөг болгсоноос гадна ЖАН СЮЭ-ЛЯНЫ явуулж буй бүхийл арга хэмжээг японы тагнуулын газарт мэдэгдэх болжээ.

Мэрсээ ярихдаа: “Мурусимагийн даалгаврын дагуу минимй бие 1928 оны 11 дүгээр сарын эхээр Түшээт ван болон Ганжууржавын дэмжлэгээр “Монголын соёлын нийгэмлэг” гэдэг байгууллагыг Мүгдэнд байгуулсан. Энэ байгууллагын зорилго нь монгол залуучууд, ноёдыг хооронд нь ойртуулах, Японтой холбоогоо сэргээхэд оршиж байв (хуудас 37).

“Өргөөд зугатан очсон үндсэрхэх үзэлт баргуудыг Баргад буцааж авчрах” талаар ЖАН СЮЭ-ЛЯНААС 1928 оны 12 дугаар сард өгсөн даалгавар, “Гадаад Монголын АХН-ын Төв Хороотой харилцаагаа сэргээх” талаар японы тагнуулын газраас өгсөн үүрэг зэргийг Мэрсээ хооронд нь “уялдуулан холбосон” ажээ.

Мэрсээ ярихдаа: “ШАОЛИН, НЯМЖАВ бид гурав Баргаас зугатсан ...хүмүүсийг Баргад буцаахыг хүссэн албан ёсны саналыг монголын яамны нэрийн өмнөөс явуулсан. үүний хамт Гадаад Монголын өнөөгийн байдлыг тодорхойлохыг (японд зориулсан ШАОЛИНЫ илтгэлд зориулж) ШАОЛИН Нямжавт үүрэг болгожээ (хуудас 116).

Нямжав Өргөөд баривчлагдаж буудуулсан учир Гадаад Монголын АХН-ын Төв Хороотой харилцах явдал бүтэлгүйтсэн.

1929 оны намар Мүгдэнд монголын семинарын захирлаар ажиллаж ЖАН СЮЭ-ЛЯНЫ даалгавраар хятадыг баримтлагч боловсон хүчнийг бэлтгэж байхдаа Токио дахь японы талыг баримтлагч мөөнголын суралцагч залуусын удирдагчдын нэг, японы агент монгол ДЕГУДАЙТАЙ холбоо тогтоосон бөгөөд Мэрсээд ямар чиглэлээр ажиллах зааварладагаас гадна Мэрсээгийн ярьсанаар: “...МУРУСИМАГААС өгсөн даалгаврыг амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаарх практик заалтыг өгдөг байсан ажээ (хуудас 38).

МУРУСИМАГИЙН даалгаврыг хэрэгжүүлэхийн хамт лам нарын нэр төрийг сэргээх ажлыг гүйцэтгэж байв.

“Лам нарын нэр хүндийг сэргээхийн тулд 1929 оны өвөл Мүгдэнд ирсэн Банчин-Богдыг ёслол төгөлдөр угтан авах ажлыг миний бие зохион байгуулсан. Семинарын бүх суралцагсад түүнд мөргөл үйлдсэн. ...сургуульд ёслолын хурал хийсэн” гэж Мэрсээ бичжээ (хуудас 38).

Мэрсээ 1930 оны хавар Хайлаарт байхдаа Гадаад Монголтой холбоогоо сэргээх даалгаврыг биелүүлээгүй тухай сануулга бичгийг ШАОЛИН болон Өмнөт Манжуурын төмөр замын салбарын Даргаас авчээ.

Мэрсээ ярихдаа: “Баргын залуучуудын хороог зохион байгуулах зэрэг... өөр арга хэрэглэхийг ШАОЛИН санал болгосон юм. Надаар дамжуулан Гадаад Монголд тагнуулын үйл ажиллагаа явуулахад энэхүү байгууллагыг ашиглах боломжтой болгохыг ШАОЛИН хүсч байв. (хуудас 28).

ШАОЛИНЫ зөвлөгөөний дагуу Мэрсээ өөрийн шавь Жабалдин нарыг Өргөөд холбоо тогтоохоор илгээсэн боловч дахиад л амжилт олоогүй юм. “Баргын байгууллагын” төлөөлөгчдийг Гадаад Монгол буцаан явуулж байв.

Гоминьданд чухал байр суурь эзэлдэг, Өвөр Монголын АХН-ын Төв Хорооны дарга асан БАЙЮНТИТАЙ Мэрсээгийн харилцааг мэдэх Японы тагнуулын газар Өмнөт Манжуурын төмөр замын Жэнзянтуний салбарын дарга КЕКУ-ТАКЕ болон Квантуны армийн штабын төлөөлөгч ЖУНЖУРЖАВ зэрэг өөрийн агентуудаараа дамжуулан нэгэнт БАЙЮНТИ зөвшөөрч байгаа учраас өөрийн үндсэрхэх үзэлт боловсон хүчнүүдийг БАЙЮНТИГИЙН хэсэгтэй нэгтгэхийг Мэрсээд санал болгожээ.

“...Өвөр Монголын АХН-ын 2 дугаар их хуралд оролцох, ...Жунжуржавыг монголын сурагчидтай,...сейм болгоны төлөөлөгчидтэй танилцуулах, Гадаад Монголтой харилцаж, тэндхийн улс төр, эдийн засгийн байдлын тухай байнгын мэдээлэл авч байхаар” шийдвэрлэжээ.

Мэрсээ ЖАН СЮЭ-ЛЯНЫГ дагалдан Нанжинд явах аас өөр аргагүй болсон учир ӨМАХН-ын 2 дугаар их хурлыг хуралдуулахтай холбогдсон ажлыг хангалттай хийж чадаагүй бөгөөд Нанжины Засгийн газрыг зохион байгуулах их хуралд оролцохоор ирсэн Өвөр Монголын ноёдтой ажил хэрэгч холбоо тогтоох даалгаврыг японы агент ДЕГУЛАЙ түүнд өгчээ. Нанжинд хүрэлцэн ирсэн ШАОЛИНТАЙ зочид буудлын нэг өрөөнд байхдаа түүний даалгавраар их хурлыг ашиглан: “...Хятадаас Монголыг эзлэн авах асуудлыг тавихыг ЖАН СЮЭ-ЛЯНД санал болгох” гэжээ.

ШАОЛИН Мэрсээд ярихдаа: “...Би ШАОЛИЗИГААР дамжуулан энэ асуудлыг шийдвэрлэхдээ Чан Кай-Шид нөлөөлөх замаар тухайн чиглэлээр нь хэрэгжүүлэх, үүнийг хэрэгжүүлэх явдлыг Чан Кай-шигээс Танд бүрэн эрх болгох явдлыг би хичээнэ, ...тэгээд Гадаад Монголд тантай хамт сэтгэл ханамжтай явна” гэжээ (хуудас 119,120).

ШАОЛИН, МЭРСЭЭ нар төлөвлөн буй асуудлаа Москвад явж буй МОДЕГУЙН төлөөлөгчдөд даалгасан асуудалтай уялдуулахыг эрмэлзсэн, харин МЭРСЭЭ өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө ЖАН СЮЭ-ЛЯНД өгчээ.

Удалгүй МЭРСЭЭ Нанжинаас Бээжинд ирэхдээ Ерөнхий штабын төлөөлөгч япон ХАОКИ И САБРОТАЙ уулзсан бөгөөд, МЭРСЭЭ ярихдаа: “...Би ДЭ ВАНГИЙН тусламжтайгаар Бээжинд аймаг, хошуудын нэгдсэн хороог байгуулж, түүний хариуцлагатай нарийн бичгийн дарга болсон, Банчин-Богдод зориулсан шүтээнийг Шилийнгол аймагт байгуулахын тулд аймаг, хошуудаас хөрөнгө хуримтлуулахаар шийдвэрлэсэн. Японы агент ХАН ФЕН-ЛИНЫГ өөрийн хошууны цэргийн сургагч хэмээн ДЭ ВАН хүлээж авчээ.” гэжээ.

Энэ ажлын зорилгыг ХАОКИ САБРОГИЙН үгээр МЭРСЭЭ

тодорхойлохдоо: "...Монгол үндэстний өмнөх үеийн хүчирхэг байдлыг эргүүлэн сэргээх, үүнд нь монгол үндэстэн ястнуудад туслахыг бид (япончууд) эрмэлзэж байна" гэжээ (хуудас 88,89).

МЕРСЕ 1931 оны 8 дугаар сард амрахаар Нанжинаас Мүгдэнд ирээд японы агент болох солонгос эмч ЖЕН СИРУНТЭЙ дараах зүйлийг тохиролцжээ. Үүнд: "...Солонгос, монгол хүн амыг хооронд нь ойртуулах ажлыг хамтарч хэрэгжүүлэх, үүний тулд Монголд эмнэлэг байгуулах явдлыг солонгос эмч хариуцах, ...Бээжинд явуулах соёл-үндэстний ажилд материаллаг тусламж үзүүлэх, ...эхнэрийнхээ авга ахаар дамжуулан солонгос амбан захирагчтай намайг танилцуулах" явдал байв (хуудас 40).

Мүгдэнийг эзлэн авах япончуудын төлөвлөгөөг хэрэгжүүлэх цаг хугацаа ойртсон, японы тагнуулын газраас өдөөн хатгасан Баргын бослогод ЗХУ хэрхэн хандаж байгааг мэдэх сонирхол өссөн зэрэгтэй холбогдон цэргийн төлөөлөгчдийн гишүүн, япон МОРИ ХАСИ Хайлаараас МЭРСЭЭТЭЙ уулзахаар Мүгдэнд ирж, МЭРСЭЭД дараах үүрэг өгчээ. Үүнд:

1. Өвөр Монголд цэргийн боловсон хүчин бэлтгэх ажил хийх,
2. Манжуурыг эзлэн авах үед Өвөр Монголд эрх чөлөөний хөдөлгөөн өрнүүлэх,
3. Бээжинд очихдоо МОР ХАСИТАЙ цуулзаж иүүнээс цаашдын ажлын даалгавар авах. (хуудас 89,90).

Хоёр долоо хоногийн дараа Мүгдэнг япончууд эзэлж авчээ. Өвөр Монголд бослого зохион байгуулахаар Мүгдэнд ирсэн Квантуны армийн штабын ах дүү монгол ГАНЖУУРЖАВ, ЖУРЖУНЖАВ болон монгол отрядын хурандаа ЭРХЭМБИЛ нарын өгсөн даалгаврыг МЭРСЭЭ баяртай хүлээн авчээ.

"...Барга болон Бутхед бослого гаргах ухуулгын ажил зохион байгуулах, ...Баргын хөдөлгөөний талаарх ЗХУ-ын байр суурийг мэдэж авах, "Баргын тусгаар тогтнол" лоозонгийн дор ажлаа явуулах, Жирмийн чуулган буюу ГАНЖУУРЖАВЫН хүчтэй холбоо тогтоож тэднээс зэвсэг авах" (хуудас 90).

Цагаантны хүчээр Баргын бослогыг дэмжих тухай Мүгдэн, Чанчуньд байхдаа атаман СЕМЕНОВААС албан ёсны зөвшөөрөл олж авсан Мэрсээ японы агент ХОЛИНТАЙ болон "өөрийн сурагч" 40 хүний хамт Хайлаарт ирж, баргуудыг босгох ажлыг зохион байгуулжээ.

НАЭРЛТ хэмээх монгол хүн "чухал хүмүүсээс" даалгавар авсаныг мэджээ. Чухал хүмүүс гэдэг нь Зөвлөлт засгийн төлөөлөгчдийг хэлж байгаа байх гэж Мэрсээ бодож байжээ. Энд нэг талаар:

"...1. Шаардлагатай үед эвдэн сүйтгэх зорилгоор Хятадын төмөр замд, Хинганы нурууны хонгилд тагнуул хийх,

2. Замыг эвдэлсний дараа партизаны отряд байгуулах”.

нөгөө талаар бол ХОЛИНТАГИЙН санал, хувийн хүсэлтийн дагуу

“...Япончууд чухамхүү өнөө үед л Баргад онцгой анхаарал хандуулж байна, Баргад гарч болох бослогод ЗХУ хэрхэн хандах бол, зэвсгийн тусламж үзүүлэх эсэх, Хятадын төмөр замд ямар нэг шуугиант явдал гарвал яах бол гэх зэргийг тэд бас их сонирхож байгаа юм” гэж Мэрсээ мэдэгджээ.

Миний зааврыг хүлээж бай хэмээн Бутхид бослого гаргах явдлыг зохион байгуулагчид, тэдний холбоочдод Мэрсээ мэдэгдэхийн хамт өөрөө Манжуур орж зөвлөлтийн консулын газарт очин ЗХУ-ыг бослогод татан оруулахыг оролджээ.

Дээр дурдсан зүйлийг үндэслэн дараах ялыг оноож байна:

МЕРСЕ буюу ГО ДАО ФУ 1894 онд төрсөн, барга - монгол, Хятадын харьяат, дээд боловсролтой, хятад, монгол, дагуур, орос хэл эзэмшсэн, англи хэл мэддэг, хоёр хошууны захирагч хийдэг түшмэл хүн, Хайлаар болон Мэхэрт тосгонд хувийн байшинтай, 20 000 хятад долларын үнэтэй Хайлаар дахь спиртийн заводтай, банканд бэлнээр 10 000 хятад доллар хадгалуулсан, 400 толгой хүртэлх үхэр сүрэгтэй, 500 хүртэл толгой бог малтай, 200 толгой адуутай.

Японы тагнуулын байгууллагын даалгавраар:

1. Тагнуулын ажил хийж байсан,

2. Өвөр Монголыг Японд эзлүүлэх зорилгод чиглүүлэн Өвөр Монгол дахь японыг баримталсан боловсон хүчнүүдийг нэгтгэх бодлого явуулж, томоохон зэвсэгт балмад явдлыг хэрэгжүүлэхээр бэлтгэж байсан,

3. ЗХУ-ыг Японы эсрэг зэвсэгт мөргөлдөөнд өдөөн хатгах оролдлого хийсэн, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 58-ын 4, 58-ын 6-д заасан гэмт хэргүүдийг үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэнээ өөрөө хүлээн зөвшөөрсөн:

ЗСБНХОУ-ын Төвийн Гүйцэтгэх Хорооны 1927 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн тогтоолыг үндэслэн МЕРСЕ буюу ГО ДАО ФУГИЙН ...дугаар бүхий хэргийг Шүүхээс гадуур хэлэлцүүлэн таслуулахаар Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын зөвлөлд явуулсугай.

1 дүгээр ОНЦГОЙ ХЭЛТСИЙН БҮРЭН ЭРХТ

1 дүгээр ОНЦГОЙ ХЭЛТСИЙН ДАРГА

“ЗӨВШӨӨРСӨН”

АДХ-ын Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын.....

ДАРГЫН ТУСЛАХ

Тайлбар:

1. Ялын дүгнэлтийг орос хэл дээр бичгийн машинаар бичжээ.

**Баримт № 6. МЕРСЕ буюу ГО ДАОФУГИЙН ТУХАЙ
ТОДОРХОЙЛОЛТ**

БАТЛАВ

ЦЭРГИЙН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ

хууль зүйн хошууч-генерал

В.С.ПАРФЕНОВ

1989 оны 5 дугаар сарын 19

Овог, нэр: МЕРСЕ буюу ГО ДАОФУ Гобол

Төрсөн он. 1894 он

Төрсөн газар. Хөлөнбуйр аймгийн Жаромт тосгон (Хятад).

Намын гишүүний байдал (гишүүний батлахын №) 1925 оноос Өвөр Монголын Ардын ажилчны намын гишүүн

Баричлагдахаас өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал. Мүгдэн хот дахь монгол семинарын захирал

Баричлагдахаас өмнө амьдарч байсан газар. Хайлаар хотоос (зүүн өмнө зүгт 60 км) Баргын нэгэн газарт

Төрөл төрөгсдийн тухай мэдээлэл: МЭРСЭЭГ баричвлагдах үед түүний гэр бүл нь эхнэр СУЙДЕ, 3 охин НАРАНГОО 14 настай, САРАНГОО 12 настай, ОДОНГОО 10 настай, Баргад амьдарч байсан. Тэдний амьдарч байсан газрын тухай мэдээлэл байхгүй.

Баривчлагдсан өдөр, оноосон ял, хэргийг хэзээ, шүүхийн бус ямар байгууллагын шийдвэр гарсан:

Манжуурын өртөөн дэх ЗХУ-ын консулын газарт 1931 оны 12 дугаар сарын 11-нд баривчлагдсан. Өвөр Монголын хэмжээнд тагнуул-өдөөн хатгах үйл ажиллагаа явуулсан, үндэсний хөдөлгөөнийг өдөөн турхирсан хэмээн Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын ажилтнууд Мэжрсээг нууцаар баривчилсан. Мөрдөн байцаах ажиллагааг эхлээд Алс Дорнодын Хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн газарт, дараа нь Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Гадаад хэлтэст явуулжээ.

Мэрсээг баривчилсан, ял тулгасан, ялын хугацааг сунгасан тухай зэрэг хэрэг шийтгэсэн баримт бичгүүд хавтаст хэрэгт нь байхгүй. Улс төрийн нэгдсэн удирдлагын газрын Зөвлөлийн 1934 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор японы тагнуулын газарт тагнуул хийсэн, зэвсэгт бослогод бэлтгэсэн, зэвсэгт мөргөлдөөнд өдөөн хатгахыг оролдсон хэмээх ялыг Мэрсээд оноож, ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлийн 4 дэх заалт, 6 дахь заалтын дагуу Мэрсээд буудан алах ял оноож, улмаар түүнийг 10 жилийн хугацаагаар хөдөлмөрийн лагерьт хорих шийтгэлээр өөрчилжээ.

МЕРСЕ буюу ГО ДАО ФУ Гобол нь “30-40-өөд он, 50-иад оны эхэн үед хэлмэгдүүлэлтэд өртсөгчдийн тухайд шудрага ёсыг тогтоох талаар авах нэмэлт арга хэмжээний тухай” хэмээх ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1989 оны 1 дүгэр сарын 16-ны өдрийн зарлигийн 1 дүгээр заалтад хамруулж байна.

Цэргийн прокурор

хууль зүйн хурандаа

ЗХУ-ын Улсын Аюулгүй байдлын Хорооны ажилтан

Дэд хурандаа

1989 оны 5 дугаар сарын 17

Тайлбар:

1. Тодорхойлолтыг орос хэл дээр бичгийн машинаар бичжээ.

ПРОТОКОЛ ДОПРОСА

1932 года мая, 24 ДНЯ Я похищен 1-м отрядом ДД

Полномочного Представительства ОГПУ по ДВК

ДОП РОСР

нижепоименованного в качестве обвиняемого с соблюдением ст. 46 УПК

П О К А З А Н

Фамилия, имя и отчество Мерсэ /То-дар-огу/.

Возраст родился в 1894 году

Национальность и подданство Монгол - Баруун "хятадский" поддан

Место рождения и приписки Барга дер. Вжаровица

Центральный архив ФСБ РФ

Настоящее местожительство

Классовая принадлежность (бывш. сословие) сын священника

Имущественное положение Круп. семьи - от 300 до 400 руб., площадь от 100 до 200 кв. м.

Профессия (специальность) машинист паровозов

6) Майларе цигеру отирати зельд отмирати около 2000 кд., цигеру 30 тмел

[illegible]

Образование Высшее Курганское, ручной Механический Колхоз
в переводнике и механике

Семейное положение женат имею 3х детей от 5 до 13 лет

Партийная принадлежность прежде и теперь *Член КСРП. Вступивший 1904 г.*

[Faint handwritten notes at the bottom of the page]

С малолетних возрастов, с все время и т.

1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100. 101. 102. 103. 104. 105. 106. 107. 108. 109. 110. 111. 112. 113. 114. 115. 116. 117. 118. 119. 120. 121. 122. 123. 124. 125. 126. 127. 128. 129. 130. 131. 132. 133. 134. 135. 136. 137. 138. 139. 140. 141. 142. 143. 144. 145. 146. 147. 148. 149. 150. 151. 152. 153. 154. 155. 156. 157. 158. 159. 160. 161. 162. 163. 164. 165. 166. 167. 168. 169. 170. 171. 172. 173. 174. 175. 176. 177. 178. 179. 180. 181. 182. 183. 184. 185. 186. 187. 188. 189. 190. 191. 192. 193. 194. 195. 196. 197. 198. 199. 200. 201. 202. 203. 204. 205. 206. 207. 208. 209. 210. 211. 212. 213. 214. 215. 216. 217. 218. 219. 220. 221. 222. 223. 224. 225. 226. 227. 228. 229. 230. 231. 232. 233. 234. 235. 236. 237. 238. 239. 240. 241. 242. 243. 244. 245. 246. 247. 248. 249. 250. 251. 252. 253. 254. 255. 256. 257. 258. 259. 260. 261. 262. 263. 264. 265. 266. 267. 268. 269. 270. 271. 272. 273. 274. 275. 276. 277. 278. 279. 280. 281. 282. 283. 284. 285. 286. 287. 288. 289. 290. 291. 292. 293. 294. 295. 296. 297. 298. 299. 300. 301. 302. 303. 304. 305. 306. 307. 308. 309. 310. 311. 312. 313. 314. 315. 316. 317. 318. 319. 320. 321. 322. 323. 324. 325. 326. 327. 328. 329. 330. 331. 332. 333. 334. 335. 336. 337. 338. 339. 340. 341. 342. 343. 344. 345. 346. 347. 348. 349. 350. 351. 352. 353. 354. 355. 356. 357. 358. 359. 360. 361. 362. 363. 364. 365. 366. 367. 368. 369. 370. 371. 372. 373. 374. 375. 376. 377. 378. 379. 380. 381. 382. 383. 384. 385. 386. 387. 388. 389. 390. 391. 392. 393. 394. 395. 396. 397. 398. 399. 400. 401. 402. 403. 404. 405. 406. 407. 408. 409. 410. 411. 412. 413. 414. 415. 416. 417. 418. 419. 420. 421. 422. 423. 424. 425. 426. 427. 428. 429. 430. 431. 432. 433. 434. 435. 436. 437. 438. 439. 440. 441. 442. 443. 444. 445. 446. 447. 448. 449. 450. 451. 452. 453. 454. 455. 456. 457. 458. 459. 460. 461. 462. 463. 464. 465. 466. 467. 468. 469. 470. 471. 472. 473. 474. 475. 476. 477. 478. 479. 480. 481. 482. 483. 484. 485. 486. 487. 488. 489. 490. 491. 492. 493. 494. 495. 496. 497. 498. 499. 500. 501. 502. 503. 504. 505. 506. 507. 508. 509. 510. 511. 512. 513. 514. 515. 516. 517. 518. 519. 520. 521. 522. 523. 524. 525. 526. 527. 528. 529. 530. 531. 532. 533. 534. 535. 536. 537. 538. 539. 540. 541. 542. 543. 544. 545. 546. 547. 548. 549. 550. 551. 552. 553. 554. 555. 556. 557. 558. 559. 560. 561. 562. 563. 564. 565. 566. 567. 568. 569. 570. 571. 572. 573. 574. 575. 576. 577. 578. 579. 580. 581. 582. 583. 584. 585. 586. 587. 588. 589. 590. 591. 592. 593. 594. 595. 596. 597. 598. 599. 600. 601. 602. 603. 604. 605. 606. 607. 608. 609. 610. 611. 612. 613. 614. 615. 616. 617. 618. 619. 620. 621. 622. 623. 624. 625. 626. 627. 628. 629. 630. 631. 632. 633. 634. 635. 636. 637. 638. 639. 640. 641. 642. 643. 644. 645. 646. 647. 648. 649. 650. 651. 652. 653. 654. 655. 656. 657. 658. 659. 660. 661. 662. 663. 664. 665. 666. 667. 668. 669. 670. 671. 672. 673. 674. 675. 676. 677. 678. 679. 680. 681. 682. 683. 684. 685. 686. 687. 688. 689. 690. 691. 692. 693. 694. 695. 696. 697. 698. 699. 700. 701. 702. 703. 704. 705. 706. 707. 708. 709. 710. 711. 712. 713. 714. 715. 716. 717. 718. 719. 720. 721. 722. 723. 724. 725. 726. 727. 728. 729. 730. 731. 732. 733. 734. 735. 736. 737. 738. 739. 740. 741. 742. 743. 744. 745. 746. 747. 748. 749. 750. 751. 752. 753. 754. 755. 756. 757. 758. 759. 760. 761. 762. 763. 764. 765. 766. 767. 768. 769. 770. 771. 772. 773. 774. 775. 776. 777. 778. 779. 780. 781. 782. 783. 784. 785. 786. 787. 788. 789. 790. 791. 792. 793. 794. 795. 796. 797. 798. 799. 800. 801. 802. 803. 804. 805. 806. 807. 808. 809. 810. 811. 812. 813. 814. 815. 816. 817. 818. 819. 820. 821. 822. 823. 824. 825. 826. 827. 828. 829. 830. 831. 832. 833. 834. 835. 836. 837. 838. 839. 840. 84

Годы, когда был издан указ

Селе. деревня Юныкино. (7 летних вооружен.)

Чи не ^{у Китаї} гинув мистецтво ірландії у воєну

года у которых ушел до Вет. Трое из них

1. *Prosa* - *1. Prosa*

1

Adonys hexony & homopori grues. The rota

После Хаймарской школы я поступил в Училище

картону маказно в которой упира 4 штуки

завербовав инструктора - буржуа
из К. Р. ЗО (французского происхождения)
при содействии последнего
бегнул в Бирму - в Чанай.
В Чанайе просидев некоторое
время, приехал в Бирму с
французскими и немецкими ин-
женерами, так же как и
французский персонал. Инокенций
Я. так же ввел с фран-
цузскими, которые мне рассказывали
свои побег из СССР.

Из разговоров французского ин-
женера, единственного вышедшего из
К. Р. ЗО в Чанайе, в Бирму. В Бирме
(арест и убийство русских, в Бирме фран-
цузский персонал с французскими ин-
женерами, в Бирме французский персонал)
и в Бирме французский персонал.
Однако, в Бирме французский
персонал не принимал участия в
работе, т. к. в Бирме
был арестован французский персонал.
Не считая того, что французский, ин-
женер, после меня не принимал
работы, но и практически
осуществлял работу. И так же в
Бирме французский персонал.
В Бирме французский персонал.

В следующем показании
я так же рассказываю о
заговоре М. М. Р. и о том, что в 1931-1932
показания о моем побеге рассказано
мне и прочитано мне.

Подпись: Мерсе 郭 道 南